



Mongolian Marketing
Consulting Group

YOUR
RESEARCH
PARTNER



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ



2020.01.10

Захиалагч: Санхүүгийн зохицуулах хороо

Зөвлөх: "Эм Эм Си Жи" ХХК

ESOMAR¹⁹
corporate





ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН САЛБАРЫН ҮНЭЛГЭЭ

ЭМ ЭМ СИ ЖИ ХХК

Зүүн хүрээ хотхон, 203-р байр, 4 давхар, 14-р хороо
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар,
Монгол Улс

Утас/Факс: 976-77000188

Мэйл: info@mmcg.mn

Веб сайт: <http://www.mmcg.mn>

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот 15160,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, ЗГ-ын IV байр

Утас: (976)-51-262789

Факс: (976)-11-329084

Веб сайт: <http://www.frc.mn/>



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС ИЙН ТАЙЛБАР	4
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХУРААНГУЙ ҮР ДҮН	6
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛС ДАХЬ МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, СЭҮ-НИЙ АРГАЧЛАЛ ...	9
БҮЛЭГ 2. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН СЭҮ-НИЙ АРГАЧЛАЛ	12
БҮЛЭГ 3. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ТОХИОЛДЛУУД	17
3.1 Мөнгө угаах үе шатууд	17
3.2 Суурь гэмт хэргүүд, тэдгээрийн нөхцөл байдал	17
БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ	21
БҮЛЭГ 5. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН МУТС ЭРСДЭЛ	26
5.1 Үнэт металл, үнэт чулуу олборлогчид	28
5.2 Үнэт металл, үнэт чулууны дундын худалдан авагчид	38
5.3. Үнэт чулуу зүсэх, өнгөлөх болон үнэт металл цэвэршүүлэх үйлчилгээ эрхлэгчид	42
5.4. Үнэт эдлэл үйлдвэрлэгчид	44
5.5. Үнэт эдлэлийн жижиглэн худалдаа эрхлэгчид	46
5.6. Үнэт эдлэлийн хоёрдогч зах зээл дээрх худалдан авагчид, худалдан борлуулагчид	50
ХАВСРАЛТ 1. ЭРДЭНИЙН ЧУЛУУНЫ АНГИЛАЛ	52
ХАВСРАЛТ 2. АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ	53
ХАВСРАЛТ 3. АЛТНЫ СОРЬЦЫГ БАТАЛГААЖУУЛЖ, ХУДАЛДАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ	56
ХАВСРАЛТ 4. ҮНЭТ ЭДЛЭЛИЙН СОРЬЦЫН БАТАЛГААНЫ ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА	57

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ам.доллар	Америкийн Нэгдсэн Улсын доллар
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
АНДББ	Ази, Номхон далайн бүсийн байгууллага
АНУ	Америкийн нэгдсэн улс
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
БТКУС	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем
ГВАН	Гадаад валютын албан нөөц
МБУНДХ	Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо
МУ	Мөнгө угаах
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МЭҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБАЗ	Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөл
ОУБ	Олон улсын байгууллага
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
СЭҮ	Салбарын эрсдэлийн үнэлгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТС	Терроризмыг санхүүжүүлэх
УИХ	Улсын Их Хурал
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮОХЗ	Үй олноор хөнөөх зэвсэг
ҮЭҮ	Үндэсний эрсдэлийн үнэлгээ
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх олон улсын байгууллага /Financial Action Task Force - FATF/
ФТБНБ	ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагууд
ХАЗ	Хамтын ажиллагааны зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХҮТ	Харилцан үнэлгээний тайлан
ЭСАЗ	Эрсдэлд суурилсан арга зүй



ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбарын хамрах хүрээ.....	13
Хүснэгт 2: Импортоор орж ирсэн 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий үнэт эдлэлийн нэгжийн үнэ.....	48
Зураг 1: Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн МУТС эрсдэлийн өнөөгийн түвшин, үйл ажиллагаа тус бүрээр.....	7
Зураг 2: Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн МУТС эрсдэлийн зураглал	8
Зураг 3: МУТС эрсдэлийн үнэлгээнүүдийн харилцан хамаарал.....	11
Зураг 4: Монголбанкнаас алт, мөнгийг худалдан авах үнэ (төгрөг/гр), 2019 оны 12 сарын 31-ний өдрийн ханш.....	31
Зураг 5: Монголбанкинд тушаасан алтны хэмжээ	32
Зураг 6: Үнэт эсвэл хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлан бүрмэл үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлсийн экспортын хэмжээ, нийт экспортын дүнд эзлэх хувь.....	33
Зураг 7: Бичил уурхайн эрхлэгчдийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд	34
Зураг 8: Алт борлуулалтын сүлжээ.....	38
Зураг 9: Үнэт эсвэл хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлан бүрмэл үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлсийн импортын хэмжээ, мян.ам.доллар.....	47

ХУРААНГУЙ ҮР ДҮН

Үндэслэл: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тухай Монгол Улсын хуулийн 4.1.8-д зааснаар 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь бэлэн мөнгөний гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-нд мэдээлэх үүрэгтэй. Түүнчлэн арилжаа хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-тэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол мөн СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

МУТСТ тухай хуулийн 3.1.12-д “үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч” гэж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнийг ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

МУТСТ тухай хуулинд 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсноор хуулийн 4.1.8-д заасан этгээд буюу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн.

Салбарын эрсдэлийн үнэлгээ (СЭҮ) нь салбар бүр дэх мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС) эрсдэлийг ойлгоход СЗХ болон мэдээлэх үүрэгтэй этгээд (МЭҮЭ)-үүдэд тусалдаг. Энэхүү салбарын эрсдэлийн үнэлгээг хийхдээ 2016 онд хийсэн Монгол Улсын МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ), 2017 онд хийсэн Харилцан үнэлгээний тайлан, Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх олон улсын байгууллага (Financial Action Task Force буюу FATF, цаашид “ФАТФ” гэх)-аас тухайн салбартай холбоотой гаргасан аргачлал, тайлан болон холбогдох бусад мэдээллийг авч үзсэн болно.


Гол дүгнэлт, санал зөвлөмж: Монгол Улсын хувьд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбар нь өөрөө өндөр эрсдэлтэй болон дундаж эрсдэлтэй суурь гэмт хэргүүдтэй шүүд холбогдож байна. Тухайлбал, хууль бусаар ашигт малтмал олборлохтой холбоотой байгаль орчны эсрэг гэмт хэрэг, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, үнэт металл, үнэт чулууг хууль бусаар хил нэвтрүүлэхтэй холбоотой авлигын гэмт хэрэг, ААНОАТ төлөхөөс зайлсхийхийн тулд албан бус сүлжээгээр алт борлуулахтай холбоотой татвараас зайлсхийх гэмт хэрэг, мөн контрабанд буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, хулгайн гэмт хэрэгт алт, үнэт металл, үнэт чулууны арилжаа оролцож байна. **Иймд уг салбарт МУТС эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлэх, МУТС-ээс урьдчилан сэргийлэхэд хууль хяналтын байгууллагын үүрэг оролцоо чухал байна.**

Террорист бүлэглэл, гэмт хэргийн бүлэглэл хяналт сул, зах хязгаар орон нутагт олборлолтын үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг. Монгол Улсын хувьд ийм тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд тохиолдох магадлал маш бага юм.

Төрөлхийн эрсдэлийн үнэлгээр Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбар нь дунджаас дээш гэсэн үнэлгээтэй байна. Үүний дотор дундын худалдан авагчид (ченжүүд) болон хоёрдогч зах зээл дээр тоглогчдын үйл ажиллагаа “өндөр эрсдэлтэй” гэж үнэлэгдсэн бол үнэт эдлэл үйлдвэрлэгчид, боловсруулах үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаа “бага эрсдэлтэй” гэж үнэлэгджээ.

Түүнчлэн МУТС эрсдэлийн өнөөгийн түвшингээр дундын худалдан авагчид (ченжүүд) болон хоёрдогч зах зээл дээр тоглогчдын үйл ажиллагаа харьцангуй өндөр үнэлэгджээ.

Зураг 1: Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн МУТС эрсдэлийн өнөөгийн түвшин, үйл ажиллагаа тус бүрээр




МУТС эрсдэлийн зураглалын **баруун дээд булан** дахь үйл ажиллагаанууд буюу дундын худалдан авагчид, хоёрдогч зах зээл дээр тоглогчдын үйл ажиллагааны хувьд - МУТС эрсдэл тохиолдох магадлал өндөр бөгөөд эрсдэлийн үзүүлэх үр нөлөө ноцтой. Эдгээр үйл ажиллагааны хувьд байнгын тусгайлсан эрчимтэй хяналтыг тавих, ажилтнуудыг тогтмол сургалтад хамруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

МУТС эрсдэлийн зураглалын **зүүн дээд булан** дахь үйл ажиллагаанууд буюу олборлогчдын болон жижиглэн худалдаалагчдын үйл ажиллагааны хувьд - МУТС эрсдэл тохиолдох магадлал бага хэдий ч эрсдэлийн үзүүлэх үр нөлөө өндөр. Энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд ажилтнуудын болон харилцагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалт сурталчилгааны ажлыг тогтмол давтамжтай зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

МУТС эрсдэлийн зураглалын **зүүн доод булан** дахь үйл ажиллагаанууд буюу боловсруулах үйлчилгээ, үзүүлэгчид, үнэт эдлэл үйлдвэрлэгчдийн хувьд - МУТС эрсдэл тохиолдох магадлал бага бөгөөд эрсдэлийн үзүүлэх үр нөлөө бага. Энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд дээр дурдсан үйл ажиллагааг харьцангуй урт хугацааны (хагас жил, жил) давтамжтай хэрэгжүүлэх шаардлагатай.

Зураг 2: Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн МУТС эрсдэлийн зураглал



БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛС ДАХЬ МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, СЭҮ-НИЙ АРГАЧЛАЛ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас анх 2006 оны 07 дугаар сарын 8-ны өдөр батлан гаргасан. Уг хуульд 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулж, 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар шинэчлэн найруулж, 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан.

МУТСТ тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "...энэ хуулийн 4.1.8-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо ...эрсдэлд суурилсан суурилсан хэлбэрээр хэрэгжүүлнэ" гэж заасан.

МУТСТ тухай хуулийн 2 дугаар бүлэгт МУТС-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр МэҮЭ болон тэдгээрийн төрийн байгууллагатай харилцах харилцааг зааж өгсөн бөгөөд уг хуулийн 3 дугаар бүлэгт эрх бүхий байгууллагуудын чиг үүргийг тодорхойлж өгсөн. Хуулийн 19.2-д зааснаар СЗХ нь МэҮЭ-үүдийн салбарын эрсдэлийн үнэлгээг хийж, салбарын МэҮЭ-үүдэд мэдээлэл, зөвлөмж өгөх үүргийг хүлээсэн байдаг.

ФАТФ-ын зөвлөмж болон олон улсын туршлагаас авч үзэхэд МУТС эрсдэлийг өөр өөр өнцгөөс нь авч үзсэн эрсдэлийн үнэлгээний гурван түвшинд авч үзсэн байдаг. Эдгээр гурван үнэлгээ нь хамтдаа МУТСТ-д туслах боломжит эрсдэлийн талаарх мэдээллийг төр засаг, эрх бүхий байгууллага, МэҮЭ-үүдэд өгдөг. Гурван эрсдэлийн үнэлгээг хослуулснаар тухайн улсад тулгарч буй МУТС эрсдэлийн дүр зургийг харуулдаг. Эдгээр гурван үнэлгээ нь хэрхэн бие биедээ мэдээлэл өгдгийг дараах зургаар харуулав (Зураг 1). Эрсдэлийн үнэлгээний гурван түвшин нь:

Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ)

ҮЭҮ нь Монгол Улсад бүхэлд нь нөлөөлж буй МУТС асуудлыг авч үзнэ. Энэ нь сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ) болон бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл дээр үндэслэдэг. Дотоодын болон олон улсын аль алиных нь төрийн байгууллагаас гаргасан мэдээлэл нь мөн ҮЭҮ-нд ашиглагдах бөгөөд аюул занал, гэмт хэргийн хандлагын өргөн хүрээтэй дүр зургийг харуулдаг. МэҮЭ-үүд ҮЭҮ-г ашиглан тулгарч буй аюул занал, хандлагын талаар мэдээлэлтэй болох ёстой. СЗХ болон бусад эрх бүхий байгууллагуудын МУТСТ сургалт хариуцсан ажилтнууд холбогдох кэйс судалгаа, бүртгэгдсэн хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг сургалт, сурталчилгааны ажилдаа ашиглах хэрэгтэй. Олон улсын туршлагаас харахад МУТС-д хүргэдэг гэмт хэргийн мөн чанарыг ойлгосон ажилтнууд МУТС үйлдлийг олж илрүүлэх, таслан зогсоох хүсэл эрмэлзэл өндөртэй байдаг болохыг олж тогтоожээ.

Салбарын эрсдэлийн үнэлгээ (СЭҮ)

МУТСТ эрх бүхий байгууллагууд нь хариуцсан салбаруудынхаа эрсдэлийн үнэлгээг гаргадаг. Эдгээр байгууллагаас гаргах МУТС салбарын эрсдэлийн үнэлгээ нь тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа МэҮЭ-үүдийн ойлголтыг сайжруулах, эрсдэлийн үзүүлэлтүүд,

хандлага, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл өгөх зорилготой. СЗХ-ноос гаргаж буй энэхүү СЭҮ нь МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4.1.8-д заасан МЭҮЭ буюу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарт МУТС эрсдэл хэрхэн нөлөөлж байгааг салбарын түвшинд авч үзнэ.

МЭҮЭ тус бүрийн эрсдэлийн үнэлгээ (МЭҮЭ-үүдээрх ЭҮ)

МЭҮЭ-үүдээрх эрсдэлийн үнэлгээ нь дараах 2 хэлбэртэй байна. Үүнд:

1. МЭҮЭ-үүдийн МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх МЭҮЭ-ийн МУТС эрсдэлийн өөрийн үнэлгээ;
2. Эрх бүхий байгууллагаас МЭҮЭ-ийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих зорилгоор тогтмол хугацааны давтамжтай хэрэгжүүлэх МЭҮЭ тус бүрийн МУТС эрсдэлийн үнэлгээ.

МЭҮЭ-ийн МУТС эрсдэлийн өөрийн үнэлгээ: Мэдээлэх үүрэгтэй этгээд (МЭҮЭ)-үүд нь өөрсдийн бизнестээ МУТС эрсдэлийн үнэлгээг хийх ёстой. МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-д МЭҮЭ-үүд МУТСТ үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан өөрийн аж ахуйн үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн бодитойгоор үнэлнэ гэж заасан. Үүнд:

1. Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;
2. Бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарч үүсэх эрсдэл;
3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;
4. Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.14-д МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг холбогдох эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална гэж заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А-26 тоот тушаалаар "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-ыг батлан гаргасан байдаг. Салбарын МЭҮЭ-үүд МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дээрх хуулийн заалт болон журмыг дагаж мөрдөх шаардлагатай.


МЭҮЭ-үүд нь МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмаа боловсруулахдаа холбогдох СЭҮ болон МУТСТ олон улсын байгууллагууд, ялангуяа ФАТФ болон АНДББ-ын гаргасан гарын авлага, удирдамжийг ашиглах хэрэгтэй.

СЗХ-ноос тогтмол хугацааны давтамжтай, МЭҮЭ тус бүрээр хийх МУТС эрсдэлийн үнэлгээ: МУТСТ тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д зааснаар СЗХ нь холбогдох МЭҮЭ-үүдэд хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, зайнаас хяналт тавих, газар дээрх шалгалт хийх зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах үүрэгтэй. Уг заалтын дагуу СЗХ нь холбогдох МЭҮЭ-үүдийн СЗХ-нд ирүүлсэн мэдээлэлд үндэслэн МЭҮЭ тус бүрээр МУТС эрсдэлийн үнэлгээг тогтмол хугацааны давтамжтай хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. МУТС эрсдэлийн үнэлгээний эрсдэлийн оноо өндөр гарахад нөлөөлсөн хүчин зүйлсийн талаарх тайлбар, тодруулга авах;

2. МУТС эрсдэлт хүчин зүйлсэд хяналт тавьж ажиллах талаарх холбогдох МэҮЭ-д заавар, зөвлөмж хүргүүлэх;
3. Шаардлагатай тохиолдолд сануулга өгөх, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Тухайлбал, тухайн МэҮЭ-ийг газар дээрх шалгалтад хамруулж, хяналт шалгалтын ажлын үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Зураг 3: МУТС эрсдэлийн үнэлгээнүүдийн харилцан хамаарал



БҮЛЭГ 2. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН СЭҮ-НИЙ АРГАЧЛАЛ

СЭҮ-ний үндэслэл: СЭҮ-нд дараах мэдээллийг ашигласан:

- Монгол Улсын Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон Харилцан үнэлгээний тайлан;
- Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-наас энэ чиглэлд хийсэн судалгаа, мэдээлэл;
- Хамтын ажиллагааны зөвлөл, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайлан;
- Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны статистик мэдээлэл;
- ФАТФ болон бүс нутгийн байгууллагаас гаргасан тухайн салбаруудын талаарх тайлан, типологи тайлан, эрсдэлд суурилсан арга зүйн удирдамж;
- Өмнө нь энэ чиглэлээр хийгдсэн үнэлгээний тайлан, мэдээлэл;
- Бусад байгууллагаас гаргасан судалгаа, тайлан мэдээлэл гэх мэт.

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт болон холбогдох бусад заалтын дагуу салбарыг дараах үзүүлэлтээр үнэлсэн:

- Харилцагч, тэдгээрээс хамаарч үүсэх нөхцөл;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх арга, хэлбэр;
- Газар зүйн байршил;
- Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа болон тодорхой төрлийн үйл ажиллагааг эрхэлж буй этгээдийн тоо, тэдгээрийн бүтэц зохион байгуулалтын хэлбэр;
- Тухайн салбарын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, дүрэм журмын тоо, хамрах хүрээ;
- Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн хууль тогтоомжийг дагаж мөрдөж буй байдал, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын тоо, төрөл хэлбэр гэх мэт.

Хамрах хүрээ: Энэхүү салбарын эрсдэлийн үнэлгээгээр МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу СЗХ-ны хяналт тавьж ажиллах уг хуулийн 4.1.8-д заасан үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд МУТС эрсдэл хэрхэн нөлөөлж байгааг салбарын түвшинд авч үзнэ.





МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 4.1.8-д зааснаар 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь бэлэн мөнгөний гүйлгээний талаар СМА-нд мэдээлэх үүрэгтэй. Түүнчлэн арилжаа хийх оролдлогыг МУТС-тэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол мөн СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

МУТСТ тухай хуулийн 3.1.12-д “үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч” гэж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнийг ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.5-д "аж ахуйн үйл ажиллагаа" гэж ашиг олох зорилготой болон тийм зорилгогүй, бүхэлд нь буюу хэсэгчлэн бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдэд зориулсан ЭСАЗ-н гарын авлагын гол хэрэглэгчид нь ФАТФ-ын зөвлөмжүүдийн хил хязгаарт хамаарах дараахь үйл ажиллагааг эрхэлж байгаа үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид байна. Уг гарын авлагд "арилжаа эрхлэгч" гэсэн нэр томъёонд дараахь өргөн хүрээтэй бизнесийн үйл ажиллагааг эрхэлж байгаа хүмүүсийг хамруулан авч үздэг.¹

Хүснэгт 1: Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбарын хамрах хүрээ

Хамаарах үйл ажиллагаа	Монгол Улсын нөхцөл байдалд хамаарах үйл ажиллагаа, тайлбар
 <p>Олборлолтын үйл ажиллагаагаар үнэт металл, үнэт чулууг үйлдвэрлэгчид</p>	<ol style="list-style-type: none"> 1. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд; 2. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхай эрхлэгчид. 3. Олборлолтын үйл ажиллагаа хууль бусаар эрхлэгчид.
 <p>Дундын худалдан авагчид болон брокер (ченжүүд)</p>	<ol style="list-style-type: none"> 1. Орон нутгийн ченж; 2. Улаанбаатар дахь ченж: <ol style="list-style-type: none"> 2.1 Аж ахуйн нэгжийн олборлосон үнэт металл, үнэт чулууг Монголбанкинд болон арилжааны банкинд тушаахад оролцож буй иргэд (ченжүүд); 2.2 Иргэдээс худалдан авсан үнэт металл, үнэт чулууг Монголбанкинд тушааж буй иргэд (ченжүүд); 2.3 Иргэд, ААН-ээс худалдан авсан үнэт металл, үнэт чулууг үнэт эдлэл үйлдвэрлэгчдэд худалдаалж буй иргэд (ченжүүд); 2.4 Иргэд, ААН-ээс худалдан авсан үнэт металл, үнэт чулууг хил давуулан худалдаалж буй иргэд (ченжүүд).
 <p>Үнэт чулууг зүсэгч, өнгөлөгчид</p>  <p>Үнэт метал цэвэршүүлэгчид</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үнэт чулуу зүсэх, өнгөлөх үйлчилгээ эрхлэгчид. 2. Үнэт металл хайлах, цэвэршүүлэх үйлчилгээ эрхлэгчид: <ol style="list-style-type: none"> 2.1 Уурхай дээрх алт ялгах, хайлах үйл ажиллагаа; 2.2 Бичил уурхайгаар олборлосон үндсэн ордын хүдрийг баяжуулах цехүүд; 2.3 Үнэт металлын сорьцын хяналтын газрын Алт хайлах цехийн үйл ажиллагаа; 2.4 Монголбанкны алт гадаадад цэвэршүүлэх үйл ажиллагаа (Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрлэл төлөвлөгдөж байгаа).

¹ Paragraph 9. "RBA Guidance for Dealers in Precious Metal and Stones", FATF/OECD, 17 June, 2018

	<p>Үнэт металл, үнэт чулууг ашиглан үнэт эдлэл үйлдвэрлэгчид</p>	<p>1. Үнэт эдлэл үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд 2. Үнэт эдлэл үйлдвэрлэгч иргэд (алт мөнгөний дархан гэх мэт).</p>
	<p>Үнэт эдлэлийг олон нийтэд жижиглэн худалдаалагчид</p>	<p>1. Дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн үнэт эдлэлийг худалдан борлуулах салбар, дэлгүүр, лангуу, орон нутаг дахь борлуулагчид; 2. Импортоор үнэт эдлэл оруулж ирж дэлгүүр, лангуу, онлайн худалдаагаар худалдан борлуулагчид.</p>
	<p>Үнэт эдлэлийн хоёрдогч зах зээл дээрх худалдан авагчид болон худалдан борлуулагчид</p>	<p>Хуучин үнэт эдлэл худалдан авч дамжуулан борлуулагчид, эртний эдлэл худалдан авч дамжуулан борлуулагчид болон эртний эдлэлийн худалдаа эрхлэгчид</p>

ФАТФ-ын зөвлөмжид үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд хамаарах дараахь зөвлөмжийг өгсөн байдаг².

- **Зөвлөмж 22:** Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь харилцагчтайгаа босго үзүүлэлт болох 15,000 ам.доллар/евро болон түүнээс дээш үнийн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээ хийх үед зөвлөмж 10, 11, 12, 15, 17-д заасны дагуу харилцагчийг таньж мэдэх, баримт бичгийг хадгалах ажлыг хийж гүйцэтгэнэ.
- **Зөвлөмж 23:** Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь босго үзүүлэлттэй тэнцүү буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг харилцагчтай хийх үед зөвлөмж 18-21-д заасны шаардлагыг ханган ажиллах буюу сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлнэ.
- **Зөвлөмж 23:** Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь МУТСТ үр дүнтэй тогтолцоог бий болгож, эрсдэлд суурилсан аргачлалыг баримтлан ажиллана.

Засгийн газрын 2010 оны 281 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үнэт металлын сорьц тогтоох баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам”-ын 6-д алт, мөнгө, платина, палладий, иридий, родий, рутений, осмий гэсэн 8 металлыг (олон улсын түвшинд мөн адил) үнэт металлын бүлэгт хамруулжээ.

Дээрх журмын мөн 6-д зааснаар эрдэнийн чулууг дараахь үнэт чулуу (5 төрөл), хагас үнэт чулуу (23 төрөл), гоёл чимэглэлийн чулуу (21 төрөл), өнгөлгөөний чулуу (7 төрөл) гэсэн 4 бүлэгт ангилж авч үзсэн байдаг (Хавсралт 1-ийг үзнэ үү).

ФАТФ-ын зөвлөмж, МУТСТ тухай хууль болон холбогдох үндэсний хууль тогтоомжид заасныг үндэслэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч гэдэгт дараахь шаардлагыг хангасан этгээдийг хамруулан энэхүү үнэлгээнд авч үзэж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2010 оны 281 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үнэт металлын сорьц тогтоох баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам”-ын 6-д алт, мөнгө, платина, палладий, иридий, родий,

² FATF, International standards on combating money laundering and the financing of terrorism and proliferation, Paris, FATF, 2012-2017

рутений, осмий гэсэн 8 **үнэт металл**, мөн журмын 6-д заасан **үнэт чулуу, хагас үнэт чулуу, гоёл чимэглэлийн чулуу** зэрэг **үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийг**

- Олборлогчид
 - Дундын худалдан авагчид болон брокер (ченжүүд)
 - Үнэт чулууг зүсэх, өнгөлөх, үнэт металлыг цэвэршүүлэх үйл ажиллагаа эрхлэгчид
 - Үнэт металл, үнэт чулууг ашиглан үнэт эдлэл үйлдвэрлэгчид
 - Үнэт эдлэлийг олон нийтэд жижиглэн худалдаалагчид
 - Хуучин эдлэл болон түүхий эд болгон худалдан авагчид болон худалдан борлуулагчид (Хүснэгт 1.-ийг үзнэ үү).
2. Ашиг олох зорилготой болон тийм зорилгогүй, бүхэлд нь буюу хэсэгчлэн бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх зорилгоор дээрх 1 дүгээрт дурдсан үйл ажиллагааг эрхэлж буй **хувь хүн, хүүлийн этгээдийг** авч үзнэ.

Хязгаарлалт: Мэдээллийн бэлэн байдлаас шалтгаалан энэ удаагийн эрсдэлийн үнэлгээ нь тодорхой хязгаарлалттай байгаа бөгөөд цаашид мэдээллийн бэлэн байдлыг нэмэгдүүлснээр илүү үр нарийвчилсан үр дүн, дүгнэлтийг хийх боломжтой болно.

Салбарын эрсдэлийн үнэлгээг дараахь 2 байдлаар хийсэн. Үүнд:

- **Салбарын “төрөлхийн” эрсдэлийн үнэлгээ.** Тухайн салбарын үйл ажиллагааны цар хүрээ, салбарын хэмжээ, МэҮЭ-үүдийн идэвхжил зэргийг үл харгалзан салбар тус бүрийн үйл ажиллагааны онцлог, үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн байдал зэргийг харгалзан тодорхойлсон “төрөлхийн” эрсдэлийн үнэлгээ.
- **Салбарын эрсдэлийн өнөөгийн түвшин.** Тухайн салбарын үйл ажиллагааны цар хүрээ, салбарын хэмжээ, МэҮЭ-үүдийн идэвхжил зэргийг харгалзан тодорхойлсон тухайн салбарт МУТС магадлал (likelihood) болон МУТС үйлдлийн тухайн салбар, байгууллагад үзүүлэх санхүү-эдийн засгийн болон нэр хүнд, итгэлцлийн үр нөлөөний түвшингээр илэрхийлсэн салбарын эрсдэлийн өнөөгийн түвшин.

Салбарын “төрөлхийн” эрсдэлийн үнэлгээ. Салбар бүрийг дараах дөрвөн эрсдэлийн үнэлгээний онооны аль нэгээр тодорхойлсон. Оноо МУТС “төрөлхийн” эрсдэл (inherent risk)-ийн үнэлгээн дээр үндэслэсэн. Эдгээр оноо нь МэҮЭ-үүд МУТС эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж хяналт, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэхгүй.



Салбарын эрсдэлийн өнөөгийн түвшин. Салбарын эрсдэлийн өнөөгийн түвшинг тодорхойлохдоо эхлээд тухайн салбарт МУТС эрсдэл тохиолдох магадлал (аюул занал болон эмзэг байдал)-ыг тодорхойлсон. Магадлалыг үнэлэхдээ төрөлхийн эрсдэлийн үнэлгээ болон салбарын хэмжээ, эргэлдэж буй хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагаа явуулж буй нэгжийн тоо зэрэг үзүүлэлтийг харгалзан дараахь хүчин зүйлсийг авч үзсэн.

Эрсдэлийн хүчин зүйлс	Магадлал өндөр (5)	Магадлал бага (1)
Салбарын хэмжээ	Олон тооны байгууллага ажилладаг Өндөр эрсдэлтэй улс оронд үйл ажиллагаа явуулдаг олон байгууллага байдаг	Цөөн эсвэл жижиг байгууллагууд ажилладаг Байгууллагууд нь зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулдаг
Бүтээгдэхүүн үйлчилгээ	Бэлэн мөнгөөр төлбөр нь хийгддэг бүтээгдэхүүн, гүйлгээний тоо олон Нарийн төвөгтэй бүтээгдэхүүнтэй Сангийн эх үүсвэр нь үргэлж тодорхой бус байдаг	Бэлэн мөнгөөр төлбөр нь хийгддэг бүтээгдэхүүн, гүйлгээний тоо хязгаарлагдмал эсвэл цөөн Энгийн бүтээгдэхүүнтэй Сангийн эх үүсвэр нь тодорхой
Гүйлгээ	Өндөр дүнтэй гүйлгээ хийгддэг Өндөр эрсдэлтэй улс оронд байгаа харилцагч руу хийсэн гүйлгээний тоо олон	Бага дүнтэй гүйлгээ хийгддэг Зөвхөн дотоодод гүйлгээ хийгддэг
Харилцагч	Гадаад улсын болон хөрөнгө ихтэй харилцагчид олонтой Нарийн төвөгтэй бүтэцтэй олон тооны харилцагчидтай	Зөвхөн дотоодын харилцагчидтай
Хүргэх суваг	Харилцагчтай хэзээ ч нүүр тулж харилцдаггүй	Харилцагчтай шууд харилцдаг

Үүний дараа тухайн салбарт МУТС эрсдэл тулгарсан үед тухайн салбарт үүсч болох үр нөлөөг санхүү-эдийн засгийн үр нөлөө, салбарын нэр хүндэд үзүүлэх үр нөлөөгөөр (1 “үр нөлөө багатай” – 5 “үр нөлөө өндөртэй”) үнэлсэн.

Тухайн салбар, үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг эрсдэл үүсэх магадлал болон эрсдэлийн үр нөлөөний үржвэр байдлаар тодорхойлсон.



БҮЛЭГ 3. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ТОХИОЛДЛУУД

3.1 Мөнгө угаах үе шатууд

Гэмт хэрэгтнүүд хууль бус мөнгө эсвэл хөрөнгөө дараах үе шатаар дамжуулан угаадаг. Үүнд:

- **Байршуулах:** Гэмт хэрэгтнүүд бохир мөнгөө санхүүгийн системд байршуулна.
- **Нуун далдлах:** Хууль бусаар олсон хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах, төөрөгдүүлэх зорилгоор олон тооны нарийн төвөгтэй гүйлгээг хийх замаар санхүүгийн системд эргэлдүүлнэ.
- **Буцаан төвлөрүүлэх:** Хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулахын тулд нэмэлт гүйлгээнүүдийг хийх замаар хөрөнгийг өөртөө эргэн татан төвлөрүүлнэ.

3.2 Суурь гэмт хэргүүд, тэдгээрийн нөхцөл байдал

Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж эдийн засгийн эргэлтэд оруулж “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлогыг мөнгө угаах гэдэг. “Бохир” мөнгийг бий болгосон гэмт үйлдэл, хэргийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг гэдэг. Мэдээлэх үүрэгтэй этгээдүүд мөнгө угаах суурь гэмт хэргийн талаарх ойлголт, мэдээлэлтэй байх хэрэгтэй.

Өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгт залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх, авлига; дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт хэрэгт хар тамхи, контрабанд буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг, хулгай, гадаадад үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө мөнгөтэй холбоотой эрсдэл багтаж байна. Эдгээр суурь гэмт хэрэг үйлдэж олсон орлогын үндсэн хэсгийг Монгол Улсад, үлдсэн хэсгийг (ялангуяа авлигын) оффшор бүсэд угааж байна³.

Дээр дурдсан өндөр болон дундаж эрсдэлтэй суурь гэмт хэргийн нөхцөл байдлыг бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл дээр үндэслэн авч үзлээ. Салбарын МэҮЭ-үүд суурь гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлс зэргийн талаар мэдээлэл, ойлголттой байж эрсдэлд суурилсан МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, түүн дотроо харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа харгалзан үзэх шаардлагатай.

Монгол Улсын хувьд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбар нь өөрөө өндөр эрсдэлтэй болон дундаж эрсдэлтэй суурь гэмт хэргүүдтэй шууд холбогдож байна. Тухайлбал, хууль бусаар ашигт малтмал олборлохтой холбоотой байгаль орчны эсрэг гэмт хэрэг, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, үнэт металл, үнэт чулууг хууль бусаар хил нэвтрүүлэхтэй холбоотой авлигын гэмт хэрэг, ААНОАТ төлөхөөс зайлсхийхийн тулд албан бус сүлжээгээр алт борлуулахтай холбоотой татвараас зайлсхийх гэмт хэрэг, мөн контрабанд буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, хулгайн

³ “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний тайлан”, Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ) 2017 оны 9 дүгээр сар.

гэмт хэрэгт алт, үнэт металл, үнэт чулууны арилжаа оролцож байна. **Иймд уг салбарт МУТС эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлэх, МУТС-ээс урьдчилан сэргийлэхэд хууль хяналтын байгууллагын үүрэг оролцоо чухал байна.**

Залилах гэмт хэрэг: Өмчлөх эрхийн гэмт хэргүүдээс хулгайлах гэмт хэргийн дараа залилан мэхлэх гэмт хэрэг хамгийн их үйлдэгдэж байна. Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-ын мэдээллээр 2018 онд улсын хэмжээнд залилах гэмт хэргийн 5,372 тохиолдол бүртгэгдсэн нь 2017 оныхоос 79.3%-өөр нэмэгджээ.⁴ Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2017 онд нийт 9,275 иргэн, 4 хуулийн этгээд хохирч, гэмт хэргийн улмаас учирсан 123.2 тэрбум төгрөгийн хохирлын 48.4 тэрбум төгрөг буюу 39.3 хувийг нөхөн төлүүлж, 26.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ. Бүртгэгдсэн залилах гэмт хэргийн дундаж хохирлын хэмжээ 41.1 сая төгрөг байжээ.⁵ Залилах гэмт хэрэг нь дараах шалтгаан нөхцөл, хүчин зүйлийн улмаас үйлдэгдэж байна. Үүнд:

(i) Залилах гэмт хэрэг гол төлөв санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас үйлдэгдэж байна. тухайлбал, амьдралын хэрэгцээний зүйл болсон гар утас, машин, орон сууц зэргийг олж авахын тулд худал ярьж түр хэрэглэхээр авч буцаан өгөхгүй байх, худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ зэрэг иргэний эрх зүйн гэрээ байгуулж итгэл эвдэх замаар залилан мэхэлж бусдад хохирол учруулсан тохиолдол их үүссэн байна. Ялангуяа зээлийн гэрээ байгуулж зээлээ эргэн төлөхгүйгээр сураггүй болох замаар залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа бөгөөд зээлтэй холбоотой гэмт хэрэг цөөнгүй үүсэж байгаа шалтгаан нь банкны зээлээ эргэн төлж чадахгүй болсон, зээлийн өрнөөс чөлөөлөгдөхийн тулд түр зур хувь хүнээс зээл авсан, банкны зээл авах шаардлага хангаагүйн улмаас зээл авах боломжгүй болсон, гэнэт мөнгө шаардлагатай болсон зэрэг санхүүгийн хүнд нөхцөлөөс шалтгаалсан байна.

(ii) Иргэдийн сонор сэрэмж сул байгааг ашиглан өөрийнхөө тухай бусдад худал ярьж эд хөрөнгө залилан мэхэлж авсан хэрэг цөөнгүй байна. Жишээлбэл, өөрийгөө захиргааны байгууллагын ажилтан гэж итгүүлж, хураамж хэлбэрээр (тухайлбал, тусгай зөвшөөрөл гаргаж өгнө, газрын эрх олгоно хэмээн худал ярьж) залилан мэхлэх хэрэг үйлдэж байна. Мөн шашин шүтлэгийг ашиглан өөрийгөө зурхайч, лам гэж худал ярьж, мөнгө эд зүйл авсан гэх мэтийн хэрэг үүссэн байна.

(iii) Нийгмийн чиг хандлага, нөхцөл байдал. Иргэд гадаад руу цагаачлах, хөдөлмөр эрхлэх, сонирхол нэмэгдсэний улмаас ашиглан гадаадад зорчих виз гаргаж өгнө гэж хуурч мэхэлснээр их хэмжээний хохирол учирч байна. Үүнээс гадна Монгол залуучуудын дунд гадаадын их дээд сургуульд суралцах сонирхол нэмэгдсэнийг ашиглан сургуульд зуучилна хэмээн хууран мэхэлж бусдын эд хөрөнгийг авах гэмт хэрэг бий болж байна.⁶

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг: Энэ төрлийн гэмт хэрэг 2017 онд улсын хэмжээнд 128 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 56 хэргээр буюу 77.8 хувиар өссөн байна. Энэ төрлийн гэмт хэрэг 2016 онд 165 бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 4.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2.7 тэрбум төгрөг буюу 55.1 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлжээ. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг нь хөдөө хээрт зэвсэг хэрэгсэл ашиглан үйлдэгддэг, харин худалдаалах, тээвэрлэх, хадгалах, ашиглах

⁴ “Улсын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ”, Цагдаагийн ерөнхий газар.

⁵ “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017”, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2018 он.

⁶ “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016”, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2017 он.

Үйлдэл нь зөвхөн худалдагч худалдан авагч нарын дунд далд хэлбэртэй явагддаг зэргээр нуугдмал шинжтэй, нийгмийн хор аюулаар их гэмт хэрэг юм. Хууль бусаар буюу зохих

Типологи жишээ #1 (Суурь гэмт хэрэг): Төв аймгийн Заамар суманд “Сүлд майнинг Ресурс” ХХК-ийн захирал, сумын Засаг даргатай хамтран хууль бусаар ашигт малтмал олборлосон, “Мон дулаан трейд” ХХК нь МҮ000211 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн хууль бус 4.5 га газарт олборлолт явуулж, 614.9 сая төгрөгийн хохирол учруулсан.

Баянхонгор аймгийн Өлзийт суманд иргэн Г, Б нар нь нөхөн сэргээлт явуулах нэрийдлээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан.

зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнасан, мод бэлтгэсэн, ашигт малтмал олборлосон, химийн хорт бодис ашигласан зэрэг үйлдэл ихэнх хувийг эзэлж байна. Ялангуяа ашигт малтмал олборлох хэрэгт төрийн албан хаагчид аж ахуйн нэгж, компанийн эзэдтэй хуйвалдах, тусгай хамгаалалттай газар хууль бус үйл ажиллагаа явуулсан хэргүүд дийлэнх хувийг эзэлж байна. Жишээ нь:

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн шалтгаан нь иргэдийн амар хялбар аргаар мөнгө олох хүсэл, амьтан ургамлын эд эрхтнийг хэрэглэвэл бие эрүүл болно гэсэн сэтгэлгээнээс үүдэлтэй байна.

Энэ төрлийн гэмт хэргийн 15 орчим хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэрэг эзэлж байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй 2,000 гаруй ААНБ, хувиараа алт олборлож байгаа 90.0 мянга орчим иргэнтэй харьцуулахад энэ гэмт хэргийн нуугдмал хэв шинж байх магадлал өндөр байна. “Нинжа” нар төрөл хэлбэрийн хувьд өргөжиж, алт, гянтболд, өнгөт чулуу, нүүрс самар зэргээр хүрээгээ тэлжээ.⁷

Татвараас зайлсхийх гэмт хэрэг: Олон улсад хийсэн криминологийн судалгаагаар бүртгэгдсэн 1 гэмт хэргийн ард 3-10 гэмт хэрэг нуугдаж байдаг бол авлига, татвараас зайлсхийх зэрэг онцлог гэмт хэргүүдийн цаана 1:100 гэмт хэрэг нуугдаж байх бүрэн магадлалтай ажээ. Монгол Улсад жилд татвараас зайлсхийсэн 60-90 татварын маргаанд эрүүгийн хэрэг үүсгэн шалгадаг гэж үзвэл дор хаяж 600-900 татвараас зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэгдсэн байх магадлалтай. Нуугдмал гэмт хэргийн улмаас улсын төсөвт төвлөрөх ёстой хэчнээн хэмжээний орлого алдагдсаныг 2015 онд баталсан Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулиар ил болсон 36 их наяд төгрөгийн орлогоос харж болно. Татвараас зайлсхийх гэмт хэрэг дараах хэлбэрээр үйлдэгдэж байна.

1. Татвар ногдох эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх газар зэргийг зах зээлийн үнээс бага үнээр борлуулсан эсвэл өндөр үнээр худалдан авснаар гэрээ хэлцэл хийх;
2. Бусад татвар төлөгчтэй үгсэн хуйвалдаж, санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт материалыг хуурамчаар үйлдэн, татвар ногдох зүйлийг нуух, санаатайгаар багасгах, өртөг зардлаа зохиомлоор өсгөж санхүүгийн тайлан тэнцэл, татварын ногдуулалт, төлөлтийн тайланг үндэслэлгүй буруу гаргах;

⁷ “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016”, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2017 он.

3. Улсын бүртгэлд бүртгүүлэхгүйгээр үйл ажиллагаа эрхлэх, НӨАТ төлөгчөөр зориуд бүртгүүлэхгүй байх;
4. Импортлолсон барааны үнийг гаалийн байгууллагад багаар, НӨАТ-ын буцаан авалтын үед өндрөөр мэдүүлэх;
5. Бусад хүний нэрээр бараа материал импортлон борлуулж татварын ногдуулалт, төлөлтийн тайланг гаргахгүй байх;
6. Улсын бүртгэлд бүртгүүлсэн хаяг, байршилдаа байхгүй, олдохгүй байх, татварын албанаас дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй байх;
7. Үнэ шилжүүлэх, нимгэн капиталжуулалт зэрэг аргыг ашиглан татвараас зайлсхийх зэрэг болно.⁸

Авлигын гэмт хэрэг: Авлигатай тэмцэх газар 2017 онд гэмт хэргийн шинжтэй 658 гомдол, мэдээллийг хүлээн авсан бөгөөд төрлөөр нь авч үзвэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан 337, хахууль авсан 63, хахууль өгсөн 76, албан тушаалтан өмч хөрөнгө завшсан 82, хөрөнгө нуусан буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн 51, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 48, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан 50, бусад 6 хэрэг байжээ.

Гомдол мэдээлэлд холбогдон шалгагдсан 709 албан тушаалтнаас төрийн улс төрийн 137, төрийн захиргааны 115, төрийн тусгай 220, төрийн үйлчилгээний удирдах 105, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 47, төрийн өмчийн хуулийн этгээдийн удирдах 41, бусад 44 албан тушаалтан холбогдон шалгагдсан байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 174 буюу 26.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээх (эрүүгийн хэрэг үүсгэх), 375 буюу 58 хувийг хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзах (эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах), 93 буюу 14.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай харьяа прокурорт шилжүүлэн шийдвэрлэжээ.

Хуульд заасан харьяаллын 1,301 үйлдэлтэй, 654 холбогдогчтой, 427 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Мөрдөн шалгасан эрүүгийн хэргээс 106-г буюу нийт шалгасан хэргийн 24.8⁹ хувийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар, 94-ийг буюу 22.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтайгаар тус тус прокурорт, 48-ыг буюу 11.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 14 буюу 3.2 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэж, 2 хэргийг түдгэлзүүлж, оны эцэст 163 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явуулж байжээ.

⁸ “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016”, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2017 он.

⁹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017”, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2018 он.

БҮЛЭГ 4. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Монгол Улсын Их хурлаас 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийг батлан гаргасан.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.1-д “терроризм” гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдаст автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг” ойлгоно гэж заасан бол 3.1.3.ё-д зааснаар “терроризмыг санхүүжүүлэх, шууд болон шууд бусаар аливаа туслалцаа, дэмжлэг үзүүлэх”-ийг “террорист үйл ажиллагаа” гэж ойлгоно гэжээ.

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 3.1.2-д “терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг”, 3.1.11-д “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.20-д заасныг” тус тус ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

Түүнчлэн Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.20-д “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах ашиглахад бүрэн үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг” ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 3.1.2-д заасан “терроризмыг санхүүжүүлэх”, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.20-д заасан “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэсэн нэр томъёог хамтад нь “терроризмыг санхүүжүүлэх” гэж тодорхойлон, энэхүү тайланд ашигласан болно.

Террорист үйл ажиллагааг хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд террористуудад хөрөнгө мөнгө шаардлагатай болдог. Үүнд алан хядагч террористуудын байрны түрээс, хоолны төлбөр гэх зэрэг энгийн зүйлс ч байж болно. Терроризмыг санхүүжүүлэх (ТС) үйл ажиллагааны шинж чанар нь мөнгө угаах (МУ) үйл ажиллагаатай олон талаараа төстэй байдаг. Гэсэн хэдий ч ТС нь эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаасаа өвөрмөгц онцлогтой.

Шинж чанарын хувьд ТС үйлдлийг олж тогтооход илүү төвөгтэй. Хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны болон хууль бус байж болох бөгөөд ихэвчлэн бага дүнтэй гүйлгээнүүд байдаг. Тиймээс ТС үйл ажиллагааны хувьд эх үүсвэр, санхүүжүүлж буй үйл ажиллагааны мөн чанарыг нууцлахад чиглэгддэг.

АНДББ-аас 2017 хийсэн Харилцан үнэлгээний тайланд “Монгол Улсын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөх магадлал харьцангуй бага байж магадгүй. Мэдээллийн нээлттэй эх сурвалжаас харахад Аль Каида, Талибан эсхүл Исламын улстай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсад бүртгэгдээгүй бөгөөд алан хядагчдыг бэлтгэдэг буюу нутгаараа дамжин өнгөрүүлдэг улс орны тоонд Монгол Улс багтдаггүй байна. Монгол Улсад террорист халдлага гарсан эсхүл террорист бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулсан гэх тохиолдол бүртгэгдээгүй аж” гэж дүгнэсэн байдаг.

Үнэт металл, үнэт чулууны арилжааны эрхлэгчдийн салбарт үнэт металл, үнэт чулууны олборлолтын үйл ажиллагааг хамруулан авч үздэг бөгөөд **террорист бүлэглэл, гэмт хэргийн бүлэглэл хяналт сул, зах хязгаар орон нутагт олборлолтын үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг. Монгол Улсын хувьд ийм тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд тохиолдох магадлал маш бага юм.**

Монгол Улсын Тагнуулын ерөнхий газраас “Монгол Улсын терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ”¹⁰-г гаргасан. Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ гэдэг нь террорист байгууллага, бүлэглэл, этгээдийн болон террор үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар зарцуулагдах хуримтлуулсан, шилжүүлсэн эд хөрөнгө, эргэлт, түүнд тавьж буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хяналт, шалгалт, тэдгээрийн аюул занал, эмзэг сул байдлын үнэлгээний нийлбэрт хийсэн дүн шинжилгээний “**таамаг**” юм.¹¹

Үнэлгээний ажлын хэсгээс хийсэн судалгаа, гишүүн байгууллагуудаас ирүүлсэн мэдээ мэдээлэлд үндэслэн дүгнэлт хийхэд Монгол Улсын Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн ерөнхий үнэлгээний түвшин **Шар** буюу “**дундаас дээш эрсдэлтэй түвшин**” (Монгол Улсад террорист гэмт хэрэг, халдлага үйлдэгдэх эрсдэл бага түвшинд боловч манай улсад терроризмын суурь нөхцөл үүсч болзошгүй нөхцөл байдлууд нь дунд түвшинд байгаа нь эрсдлийг “дундаас дээш” түвшин рүү нэмэгдүүлж байна)-д гарсан тул Монгол Улсын хэмжээнд терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эрсдэлийн үнэлгээ хийсэн салбар	Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ	ҮОХЗ дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ
Банкнаас бусад санхүүгийн байгууллага	57.5%	62.5%
Үл хөдлөх хөрөнгө зуучлал	60.0%	62.5%
Арилжааны банк	41.25%	50.0%
Хуулийн этгээд - Ашгийн байгууллага	47.5%	50.0%
Хуулийн этгээд - Төрийн бус байгууллага	62.5%	65.0%
Хилийн хяналт	48.75%	60.0%

Энд: 0-20% эрсдэлгүй, 21-40% бага эрсдэлтэй, 41-60% дунд эрсдэлтэй, 61-80% өндөр эрсдэлтэй, 81-100% бодит эрсдэлтэй.

¹⁰ Монгол Улсын Тагнуулын ерөнхий газар: <https://gia.gov.mn/5/item/548>

¹¹ Аргачлалыг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://gia.gov.mn/5/item/548> линкээр орж үзнэ үү.

МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 6¹.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.17, 3.1.18-д заасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд үйлчилгээ үзүүлэхийг хориглоно” гэж заасан байдаг. МУТСТ тухай Монгол Улсын хуулийн 6¹ дүгээр бүлэгт заасны дагуу МЭҮЭ дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

1. Харилцагч, түүний гүйлгээг хүлээн авагч этгээд хориг арга хэмжээний жагсаалтад орсон орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэл мөн эсэхийг таньж мэдэх;
2. Хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож, энэ тухай тагнуулын байгууллага, Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлэх;
3. МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, шаардлагатай бол хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан арга хэмжээг авна.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.17-д “хориг арга хэмжээний жагсаалт” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг”, 3.1.18-д “дотоодын жагсаалт” гэж үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотойгоор терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг” тус тус ойлгоно гэж заасан байдаг.

Иймд МЭҮЭ-үүд нь дээр дурдсан хориг арга хэмжээний жагсаалт болон дотоодын жагсаалтыг үйл ажиллагаандаа ашиглаж, харилцагчийг таньж мэдэж, хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гол үзүүлэлт болон анхаарах зүйлс

ТС-тэй холбоотой байж болзошгүй илтгэх зарим анхаарах зүйлсийг орууллаа. Энэ нь бүх боломжит хувилбар биш бөгөөд МЭҮЭ өөрсдийн бизнесийн үйл ажиллагааны онцлогт тохируулан гарч болох бусад хүчин зүйлсийг ч уг жагсаалтад оруулах шаардлагатай.

- Өндөр эрсдэлтэй бүс нутагт байрлах хүлээн авагчид руу харилцагч олон тооны хөрөнгийн шилжүүлэг хийх;
- Хувь хүн болон ААНБ-ууд террорист байгууллага эсвэл терроризм, ТС-тэй холбоотой гэж тодорхойлогдсон болон тэдгээртэй холбоотой байж болзошгүй гэж сэжиглэгдэж байгаа байгууллагууд руу хөрөнгө шилжүүлэх;
- Олон харилцагч нэг ижил хаяг, утасны дугаарыг ашиглан дансны гүйлгээ хийх (үйл ажиллагаа явуулах);
- Хуурамч бичиг баримтаар данс нээлгэх;
- Мөргөлдөөнтэй байгаа бүс нутгаас эргэж ирсэн эсвэл тэнд байгаа харилцагчид;

- Харилцагчийн төлөв байдалтай нийцтэй бус байдлаар түүний дансны үйл ажиллагаа гэнэт идэвхжих;
- Нэг данс руу бага дүнтэй олон тоотой хийгдсэн дотоодын шилжүүлэг гэх мэт.

ТС эрсдэл хурдан өөрчлөгдөж байгаа учраас ТС эрсдэлийн үнэлгээг хийхдээ илүү алсыг харсан байдлаар, шинээр үүсч буй нөхцөл байдлыг соргогоор харж хамруулж авч үзэхийг салбарын МЭҮЭ-үүдэд зөвлөж байна. МЭҮЭ-үүд нь өөрсдийн МУТСТ арга хэмжээ, журамдаа эдгээр шинээр үүсэж буй ТС нөхцөл байдлыг зохих хэмжээнд үр дүнтэй хамруулж, байнга хяналт тавьж, туршиж байх хэрэгтэй.

МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд МЭҮЭ-үүд нь дараах хоёр бүлэг хориг арга хэмжээний шинэчлэгдсэн жагсаалтыг харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа байнга ашиглах шаардлагатай. Үүнд:

1. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалт (United Nations Security Council Consolidated List)¹²;
2. ФАТФ-аас гаргасан хориг арга хэмжээ авах улс орнуудын “хар жагсаалт” болон МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой улс орнуудын “саарал жагсаалт”.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалт: МЭҮЭ-үүд НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн хориг арга хэмжээний мэдээлэл бүхий дээрх линкээр орж хамгийн сүүлийн үеийн шинэчлэгдсэн хориг хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн мэдээллийг (pdf, xml, html хэлбэрээр) татан авч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай.

Уг жагсаалтад хувь хүн болон хуулийн этгээд, бүлэглэл гэсэн 2 жагсаалтаас бүрдэх бөгөөд латин цагаан толгойн үсгийн дарааллаар эрэмбэлсэн байдаг. Жагсаалтад тухайн этгээдийг таньж мэдэхтэй холбоотой боломжит мэдээллийг тухайлбал, хувь хүний хувьд дөрвөн төрлийн нэр, эх хэл дээр нь хэрхэн бичигдсэн байдаг, төрсөн газар, төрсөн огноо гэх мэт мэдээллийг багтаасан байдаг.

ФАТФ-аас гаргасан жагсаалт: ФАТФ-аас 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дараах улс орныг өндөр эрсдэлтэй (high-risk) “хар жагсаалт” дахь улс орноор тодорхойлсон байгаа бөгөөд эдгээр улсын эсрэг хориг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж тодорхойлсон байна. Үүнд:

1. Иран (Iran)¹³;
2. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (Democratic People’s Republic of Korea)¹⁴

Түүнчлэн дараах улс орныг ФАТФ-аас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой (other monitored jurisdictions) гэж тодорхойлж “саарал жагсаалт”-д оруулсан байна. Үүнд:

1. Бахамын арлууд (Bahamas);
2. Ботсвана (Botswana);
3. Камбож (Cambodia);

¹² <https://www.un.org/securitycouncil/content/un-sc-consolidated-list>

¹³ <https://www.fatf-gafi.org/countries/#Iran>

¹⁴ [https://www.fatf-gafi.org/countries/#Democratic%20People's%20Republic%20of%20Korea%20\(DPRK\)](https://www.fatf-gafi.org/countries/#Democratic%20People's%20Republic%20of%20Korea%20(DPRK))



4. Гана (Ghana);
5. Исланд (Iceland);
6. Монгол (Mongolia);
7. Пакистан (Pakistan);
8. Панам (Panama);
9. Сири (Syria);
10. Тринадад ба Тобаго (Trinidad and Tobago);
11. Йемен (Yemen);
12. Зимбабве (Zimbabwe)¹⁵.

Салбарын МэҮЭ-үүд ФАТФ-ын вэб хуудсанд тогтмол зочилж, “хар жагсаалт” болон “саарал жагсаалт”-д орсон улс орнуудын мэдээллийг авч, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаандаа тогтмол ашиглах шаардлагатай.

¹⁵ <https://www.fatf-gafi.org/countries/#other-monitored-jurisdictions>

БҮЛЭГ 5. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН МУТС ЭРСДЭЛ




Бага

Дунджаас доош

Дунджаас дээш

Өндөр

ДД	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны хамрах хүрээ	МУТС төрөлхийн эрсдэл
1	 Үнэт металл, үнэт чулуу олборлогчид	<ol style="list-style-type: none"> Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд; Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхай эрхлэгчид. Олборлолтын үйл ажиллагаа хууль бусаар эрхлэгчид. 	<p>Төрөлхийн эрсдэлийн түвшин дунджаас дээш. Хуулийн этгээдүүдийн хувьд олборлолтын тусгай зөвшөөрөл авах, хяналт тавих, харилцагч – худалдан авагчид нь хуулиар зохицуулагдсан. Татвараас зайлсхийх зорилгоор иргэний нэр дээр алтаа тушаах магадлалтай. Бичил уурхай эрхлэгчид, хууль бусаар ашигт малтмал олборлогчдын хувьд дундын худалдан авагч (ченж)-идтай бэлэн мөнгөөр арилжаа хийдэг. Гэхдээ нэг удаагийн гүйлгээний дүн 20.0 сая төгрөгөөс бага байх магадлалтай.</p>
2	 Үнэт металл, үнэт чулууны дундын худалдан авагчид	<ol style="list-style-type: none"> Орон нутгийн ченж; Улаанбаатар дахь ченж: <ol style="list-style-type: none"> Аж ахуйн нэгжийн олборлосон үнэт металл, үнэт чулууг Монголбанкинд болон арилжааны банкинд тушаахад оролцож буй иргэд (ченжүүд); Иргэдээс худалдан авсан үнэт металл, үнэт чулууг Монголбанкинд тушааж буй иргэд (ченжүүд); Иргэд, ААН-ээс худалдан авсан үнэт металл, үнэт чулууг үнэт эдлэл үйлдвэрлэгчдэд худалдаалж буй иргэд (ченжүүд); Иргэд, ААН-ээс худалдан авсан үнэт металл, үнэт чулууг хил давуулан худалдаалж буй иргэд (ченжүүд). 	<p>Төрөлхийн эрсдэлийн түвшин өндөр. Үнэт метал, үнэт чулуу худалдан авч байгаа хөрөнгийн эх үүсвэрийг хууль бус эх үүсвэрээр бүрдүүлэх магадлалтай. Бэлэн мөнгөөр өндөр дүнтэй гүйлгээ хийдэг. Үнэт металл, үнэт чулууг хууль бусаар хил давуулах, татвараас зайлсхийх, залилан зэрэг суурь гэмт хэргүүдтэй холбогдох магадлалтай.</p>
3		<ol style="list-style-type: none"> Үнэт чулуу зүсэх, өнгөлөх үйлчилгээ эрхлэгчид. Үнэт металл хайлах, цэвэршүүлэх үйлчилгээ эрхлэгчид: 	<p>Эрсдэл бага. Цөөн тооны тодорхой нэгж үйл ажиллагаа явуулдаг. Хяналт тавих боломжтой, хууль тогтоомжоор үйл ажиллагааг нь зохицуулдаг. Шүгэл үлээгчийн үүрэг гүйцэтгэх боломжтой.</p>

	<p>Үнэт чулуу зүсэх, өнгөлөх болон үнэт металл цэвэршүүлэх үйлчилгээ эрхлэгчид</p>	<ol style="list-style-type: none"> 2.1 Уурхай дээрх алт ялгах, хайлах үйл ажиллагаа; 2.2 Бичил уурхайгаар олборлосон үндсэн ордын хүдрийг баяжуулах цехүүд; 2.3 Үнэт металлын сорьцын хяналтын газрын Алт хайлах цехийн үйл ажиллагаа; 2.4 Монголбанкны алт гадаадад цэвэршүүлэх үйл ажиллагаа (Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрлэл төлөвлөгдөж байгаа). 	
<p>4</p>	 <p>Үнэт эдлэл үйлдвэрлэгчид</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үнэт эдлэл үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд 2. Үнэт эдлэл үйлдвэрлэгч иргэд (алт мөнгөний дархан гэх мэт). 	<p>Эрсдэл бага. Дүрэм журам, стандарт зэрэг зохицуулалттай, үйлдвэрлэл эрхлэгчид сорьцын дүрмийн дагуу сорьцын баталгаа хийлгэх хандлага нэмэгдэж байгаа. Үүгээр дамжуулан бүртгэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах боломжтой.</p>
<p>5</p>	 <p>Үнэт эдлэлийн жижиглэн худалдаа эрхлэгчид</p>	<ol style="list-style-type: none"> 1. Дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн үнэт эдлэлийг худалдан борлуулах салбар, дэлгүүр, лангуу, орон нутаг дахь борлуулагчид; 2. Импортоор үнэт эдлэл оруулж ирж дэлгүүр, лангуу, онлайн худалдаагаар худалдан борлуулагчид. 	<p>Эрсдэл дунджаас доош. Дүрэм журам, стандарт зэрэг зохицуулалттай. Гүйлгээний дүн босго хэмжээнээс (20.0 сая төгрөг) давах магадлал багатай. Харьцангуй олон тооны хувь хүн ажилладаг, импортын үнэт эдлэлийн хувьд хуурамч, баталгаагүй бүтээгдэхүүн борлуулах магадлалтай.</p>
<p>5</p>	 <p>Үнэт эдлэлийн хоёрдогч зах зээл дээрх худалдан авагчид болон худалдан борлуулагчид</p>	<p>Хуучин үнэт эдлэл худалдан авч дамжуулан борлуулагчид, эртний эдлэл худалдан авч дамжуулан борлуулагчид болон эртний эдлэлийн худалдаа эрхлэгчид</p>	<p>Төрөлхийн эрсдэлийн түвшин өндөр. Үнэт эдлэл худалдан авч байгаа хөрөнгийн эх үүсвэрийг хууль бус эх үүсвэрээр бүрдүүлэх магадлалтай. Бэлэн мөнгөөр өндөр дүнтэй гүйлгээ хийдэг. Үнэт эдлэлийг хууль бусаар хил давуулах, хулгай, авлига, залилан зэрэг суурь гэмт хэргүүдтэй холбогдох магадлалтай. Өндөр эрсдэлтэй харилцагчидтай.</p>

5.1 Үнэт металл, үнэт чулуу олборлогчид



Бага

Дунджаас доош

Дунджаас дээш

Өндөр

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хууль (АМТХ)-ийн 7.1-д “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын журмаар олгоно”, 7.3-д “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ” гэж тус тус заасан байдаг.

АМТХ-ийн 4.1.6-д “Ашигт малтмал ашиглах” гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг, 4.1.16-д “ашиглалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичгийг тус тус ойлгоно гэж заасан байдаг.

АМТХ-ийн дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд үнэт металл ашиглах, байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх хуулийн зохицуулалттай. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл явц, бүрдүүлэх материалын талаарх мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү.

АМТХ-ийн 4.1.23-д “бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг ойлгоно гэж заасан байна.

Дээрх хуулийн тодорхойлолт болон бусад судалгаа, мэдээллээс¹⁶ үнэт металл, үнэт чулуу олборлох үйл ажиллагааг дараахь 3 хэлбэрээр явуулж байна гэж үзэж болохоор байна. Үүнд:

4. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд;
5. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхай эрхлэгчид.
6. Олборлолтын үйл ажиллагаа хууль бусаар эрхлэгчид.

¹⁶ “A Rapid Assessment of Gold and Financial Flows linked to Artisanal and Small-Scale Gold Mining in Mongolia: Follow the Money: Mongolia”, UNIDO, The Global Initiative Against Transnational Organized Crime, Levin Resources, GEF, October 2017



Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд. Дээр дурдсан жагсаалтын 1, 2-т дурдсан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд болон холбогдох журмын дагуу бичил уурхай эрхлэгчдийн хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу олборлосон үнэт металл, эрдэнийн чулуугаа бүртгүүлж, худалдан борлуулдаг. Үүнд:

46.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон бүх төрлийн үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар тогтоолгож, тоо хэмжээг бүртгүүлнэ.

46.2. Энэ хуулийн 46.1-д заасны дагуу бүртгүүлбэл зохих үнэт металл, эрдэнийн чулууны жагсаалт, тэдгээрийн сорьц, чанарыг тогтоох, бүртгэх журмыг Засгийн газар батална.

46.3. Үнэт металл, эрдэнийн чулууг Монголбанк худалдан авч төлбөр хийхдээ олон улсын зах зээлийн үнийг баримтална.

46.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон үнэт металл, эрдэнийн чулууг Монголбанкаар дамжуулан экспортод гаргаж болно.

46.5. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 400 граммаас дээш жинтэй, эсхүл түүнээс хөнгөн боловч онцгой чамин дүрс хэлбэртэй байгалийн төрц алт, түүнчлэн ховор өнгө, дүрстэй эрдэнийн чулуу олборлосон бол тэдгээрийг Монголбанкны төрийн эрдэнэсийн санд урамшуулалтай үнээр худалдах үүрэгтэй.

Алтны сорьцыг баталгаажуулж, худалдахад бүрдүүлэх материалын жагсаалтыг Хавсралт 3-аас үзнэ үү.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд болон холбогдох журмын дагуу бичил уурхай эрхлэгчдийн үнэт металл, үнэт чулууны арилжааны зураглал



Ашигт малтмалын тухай хууль болон Эрдэнэсийн сангийн тухай хууль, Сорьцын хяналтын дүрэм, Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журмын дагуу олборлогчид нь олборлосон бүх төрлийн үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар тогтоолгож, тоо хэмжээг бүртгүүлэх, ийнхүү бүртгүүлсний дараа зөвхөн Монголбанкинд эсвэл Монголбанкаар дамжуулан экспортод гаргах боломжтой. Эдгээр хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн хариуцлага хүлээнэ.

Сорьцын хяналтын лаборатори зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байсан бол 2018 оны 10 дугаар сард Дархан-Уул, Баянхонгор аймагт сорьцын лаборатори байгуулан, алт худалдан авалтын нэг цэгийн үйл ажиллагааг эхлүүлсэн.


Үнэт металл, үнэт чулууг Сорьцын хяналтын байгууллагад бүртгүүлэх, Монголбанкинд худалдах, Монголбанкаар дамжуулан Гаалийн байгууллагад бүртгүүлэн экспортод гаргах тухай бүрт **холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэлийн үйл ажиллагаа хийгдэж байгаа учраас эдгээр шатанд харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх тохиолдолд энэ чиглэлд МУТС эрсдэл харьцангуй бага байна.**

Түүнчлэн **Монголбанк** нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болох 5 хувийг суутган, **алтны үнийг тухай бүр иргэн, аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлдэг.** Монголбанкны 1 гр цэвэршүүлсэн алт (999 сорьцтой)-ыг худалдан авах ханш 132,948 төгрөг (2019 оны 12 сарын 31-ний өдрийн ханшаар)¹⁷ байсан, Монгол Улсад олборлож байгаа

¹⁷ <https://www.mongolbank.mn/dblistgoldsilverprice.aspx?vYear=2019&vMonth=12>

алтны дундаж сорьц 900 байдаг¹⁸ гэж үзвэл бохир жингээр 170 гр алтны үнэлгээ 20,885,490 төгрөг (МУТСТ тухай хуулийн 4.1.8-д заасан босго болох 20 сая төгрөг) болж байгаа бөгөөд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ, 5%) болох 1,044,275 төгрөгийг суутгасны дараа, алт тушаагч иргэн, аж ахуйн нэгжийн дансанд 19,841,216 төгрөгийг шилжүүлэхээр байна.

Зураг 4: Монголбанкнаас алт, мөнгийг худалдан авах үнэ (төгрөг/гр), 2019 оны 12 сарын 31-ний өдрийн ханш



Монголбанкинд тушаасан алтны нийт дүнд аж ахуйн нэгжүүдийн тушаасан алтны эзлэх хувь 2014 онд 74.4% байсан бол тасралтгүй буурсаар 2018 онд 42.8%-д хүрчээ. Энэ нь дундаж хэмжээний уул уурхайн компаниуд Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) зэрэг татвараас зайлсхийх зорилгоор хувь хүний нэр дээр алтыг тушааж байгаатай холбоотой.¹⁹ Нөгөө талаас бичил уурхай эрхлэгчид болон хууль бусаар алт олборлогчдын олборлосон алтыг худалдан авдаг дундын зуучлагчид буюу ченжүүдийн оролцоо нэмэгдсэнтэй холбоотой.

Тиймээс Монголбанк алт тушааж буй иргэдийн хувьд дараахь зүйлсийг тодруулж, харилцагчийг таньж мэдэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.

1. Улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлсон улсын иргэн болон ААНБ, НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, бүлэг нэгдэл эсэх.
2. Өндөр болон дундаж эрсдэлтэй гэж тодорхойлсон суурь гэмт хэрэгт холбогдож байсан эсэх эсвэл тэдгээртэй холбоотой ажил, үйл ажиллагаа эрхэлдэг эсэх.
3. Алт тушаагч иргэний эрхэлж буй ажил, үйл ажиллагааны чиглэл алтны арилжаатай холбоотой эсэх.
4. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны олборлолт хийж буй аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгч, хамаарал бүхий этгээд эсэх.
5. Тушааж буй алтны гарал үүсэл буюу аль уурхайгаас хэн олборлосон болохыг тодруулах.


¹⁸ “Үнэт металл, эрдэнийн члууны олборлолт, үйлдвэрлэл, худалдааны өнөөгийн байдал”, Швейцарийн хөгжлийн агентлаг, Үнэт металлын сорьцын хяналтын газар.

¹⁹ “A Rapid Assessment of Gold and Financial Flows linked to Artisanal and Small-Scale Gold Mining in Mongolia: Follow the Money: Mongolia”, UNIDO, The Global Initiative Against Transnational Organized Crime, Levin Resources, GEF, October 2017

6. Огцом өөрчлөгдсөн өндөр дүнтэй эсвэл анх удаа гүйлгээ хийж байгаа гэх мэт.

Дундын зуучлагчид буюу ченжүүдийн хувьд алтыг худалдан авах санхүүгийн эх үүсвэрийг хууль бус эх үүсвэрээр бүрдүүлсэн байх магадлалтай.


Зураг 5: Монголбанкинд тушаасан алтны хэмжээ



Гаалийн ерөнхий газрын Статистикийн хэлтсийн мэдээллээр 2018 оноос 2019 оны 10 сарын 31 хүртэлх хугацаанд БТКУС-ийн ангиллын 71 дүгээр бүлэг буюу Жинхэнэ эсвэл таримал сувд, үнэт эсвэл хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлан бүрмэл үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлст хамаарах 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий барааны экспортын гаалийн мэдүүлэг 51 бүртгэгджээ. Эдгээр мэдүүлэгийн

- 28 нь "110" гэсэн горимтой Монголбанкны цэвэршүүлэхээр Швейцари улс руу гаргасан цэвэршүүлээгүй алтны;
- 1 нь мөн "110" гэсэн горимтой Монголбанкны цэвэршүүлэхээр Швейцари улс руу гаргасан цэвэршүүлээгүй мөнгөний;
- 4 нь цэвэршүүлэн худалдахаар Турк улс руу экспортолсон мөнгөн гулдмайн;
- 11 нь арилжааны зориулалтаар БНХАУ руу экспортолсон байгалийн хас чулууны;
- 5 нь Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын үйлдвэрлэгчдийн дэмжих холбоо болон бусад байгууллагын үзэсгэлэн худалдаанд зориулан БНХАУ руу экспортолсон гоёл, бэлэг дурсгалын болон үнэт эдлэлийн;
- 1 нь "202" гэсэн горимтой дотоодын үнэт эдлэл үйлдвэрлэгчийн цэвэршүүлэх, боловсруулах зорилгоор БНСУ руу хил гаргасан цэвэр цагаан мөнгөний;
- 1 нь "300" гэсэн горимтой иргэний ОХУ-аас БНХАУ руу гаргасан байгалийн ногоон хаш чулууны мэдүүлэг тус тус байжээ.

Зураг 6: Үнэт эсвэл хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлан бүрмэл үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлсийн экспортын хэмжээ, нийт экспортын дүнд эзлэх хувь



Монгол Улсад мөнгөний ордууд байдаг, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон хэдий ч одоогоор албан ёсоор олборлолт хийгдэж эхлээгүй байна. Алт, зэсийн олборлолтын явцад гарган авсан мөнгийг Монголбанкинд тушаах эсвэл экспортод гаргаж байна.

Түүнчлэн өнөөдрийн байдлаар Монгол Улсад эрдэнийн чулууны албан ёсны хайгуул, олборлолт хийгдэхгүй байгаа бөгөөд 1950-1980-аад оны үед хайгуул хийж, илрүүлсэн 160 орчим орд, илрэц тэмдэглэгдснээс зарим ордыг ашигласан. Манай оронд одоогоор үнэт чулууны орд илэрц илрээгүй байгаа боловч анар, усан биндэръяа, болор, молор, мана, гартаам зэрэг хагас үнэт чулууны ордуудыг тодорхой хэмжээгээр ашиглаж байсан.²⁰

Холбогдох журмын дагуу бичил уурхай эрхлэгчид. Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо ТББ байгуулагдсанаас хойш өдгөө 15 аймгийн 45 суманд 70 гишүүн байгууллагатай, 429 нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон нийт 6,500 гаруй гишүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. МБУНДХ нь гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, дуу хоолойгоо бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэх зорилгоор нэгдэн ажиллаж байна. МБУНДХ нь бичил уурхайн чиглэлээр нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулан нөхөн сэргээлт хийж орон нутагтаа хүлээлгэж өгдөг, хариуцлагатай бичил уурхайчдыг бий болгох, мөн орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.

²⁰ “Үнэт металл, эрдэнийн чулууны олборлолт, үйлдвэрлэл, худалдааны өнөөгийн байдал”, Швейцарийн хөгжлийн агентлаг, Үнэт металлын сорьцын хяналтын газар.

Зураг 7: Бичил уурхайн эрхлэгчдийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд



Эх үүсвэр: Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо ТББ - <https://bichiluurhai.mn/>

Бичил уурхай эрхлэгчдийн хувьд олборлосон үнэт металл, үнэт чулуугаа шууд өөрсдөө Сорьцын хяналтын байгууллагад бүртгүүлэх, Монголбанкинд худалдах тухай бүрт **холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэлийн үйл ажиллагаа хийгдэж байгаа учраас эдгээр шатанд харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх тохиолдолд энэ чиглэлд МУТС эрсдэл харьцангуй бага байна.**

Бичил уурхай эрхлэгчдийн хувьд үнэт металл, үнэт чулууны арилжаанд дундын худалдаачид буюу ченжүүд оролцох талтай. Бичил уурхай эрхлэгчдийн нөхөрлөлд олборлосон алтаа сорьцын хяналтын байгууллагад бүртгүүлж, Монголбанкинд худалдахыг эрмэлзэж ажиллаж, **дундын зуучлагчдад худалдах тохиолдолд харилцагчийг таньж мэдэх ажиллагаа үйл ажиллагааг хэрэгжүүлж, бүртгэл хөтөлж, сэжигтэй гүйлгээ, эрсдэлтэй харилцагчдын талаар мэдээлэх үүрэгтэй талаар ойлголт, мэдлэг мэдээлэл өгөх шаардлагатай.** Энэ ажлыг мэргэжлийн холбоо болох Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо ТББ-тай хамтран хэрэгжүүлэх боломжтой.

Олборлолтын үйл ажиллагаа хууль бусаар эрхлэгчид. АНДББ-аас 2017 оны 9 дүгээр сард гаргасан “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний тайлан”-д байгаль орчны эсрэг гэмт хэргийг өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийн нэгээр нэрлэсэн байна²¹.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг нь хөдөө хээрт зэвсэг хэрэгсэл ашиглан үйлдэгддэг, харин худалдаалах, тээвэрлэх, хадгалах, ашиглах үйлдэл нь зөвхөн худалдагч худалдан авагч нарын дунд далд хэлбэртэй явагддаг зэргээр нуугдмал шинжтэй, нийгмийн хор аюулаар их гэмт хэрэг юм. Хууль бусаар буюу зохих зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнасан,

²¹ “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний тайлан”, Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ) 2017 оны 9 дүгээр сар.

мод бэлтгэсэн, ашигт малтмал олборлосон, химийн хорт бодис ашигласан зэрэг үйлдэл ихэнх хувийг эзэлж байна. Ялангуяа ашигт малтмал олборлох хэрэгт төрийн албан хаагчид аж ахуйн нэгж, компанийн эзэдтэй хуйвалдах, тусгай хамгаалалттай газар хууль бус үйл ажиллагаа явуулсан хэргүүд дийлэнх хувийг эзэлж байна. Жишээ нь: Төв аймгийн Заамар суманд “Сүлд майнинг Ресурс” ХХК-ийн захирал, сумын Засаг даргатай хамтран хууль бусаар ашигт малтмал олборлосон, “Мон дулаан трейд” ХХК нь МҮ000211 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн хууль бус 4.5 га газарт олборлолт явуулж, 614.9 сая төгрөгийн хохирол учруулсан. Баянхонгор аймгийн Өлзийт суманд иргэн Г, Б нар нь нөхөн сэргээлт явуулах нэрийдлээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан.²²

Дээрх жишээнээс харахад хууль бусаар олборлолтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд дараахь 2 ангилалд хувааж авч үзэж болохоор байна.

1. Тодорхой талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хэдий ч зөвшөөрөлгүй талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй, тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн хууль бус олборлолт хийж буй хуулийн этгээдүүд;
2. Хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэд.

Хууль бус олборлолт хийж буй хуулийн этгээдийн үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн иргэд, цагдаа хууль хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

Хууль бусаар олборлосон алтыг **дундын зуучлагчдаар дамжуулан Монголбанкинд тушаах** эсвэл **хууль бусаар хил давуулан борлуулах** арга зам байна.

Хууль бусаар олборлосон алтыг борлуулах шатанд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Монголбанкинд иргэд, аж ахуйн нэгжээс алт худалдан авч байгаа үйл ажиллагаан дахь бүртгэл, хяналтыг сайжруулах замаар **дундын худалдан авагчид (ченжүүд), тэдний хөрөнгийн эх үүсвэр, худалдан авсан алтны гарал үүсэлд тавих хяналтыг бий болгох.**
- Тагнуулын байгууллага, гаалийн байгууллага зэрэг хууль хяналтын байгууллага дахь **алт хууль бусаар хил давуулах гэмт хэргийн мэдээлэл, судалгаанд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.**

Бичил уурхайгаар эсвэл хууль бусаар алт олборлож байгаа иргэд алтаа шууд Монголбанкинд тушаахгүй байгаа нь дараахь шалтгаантай байна. Хэдийгээр орон нутагт сорьц тогтоох лаборатори байхгүй, Монголбанк шууд худалдаж авдаггүй гэж байгаа боловч хамгийн гол нь иргэдийн олборлосон алт нь тухайн өдрийн амьдралыг нь залгуулах орлогын эх үүсвэр болдог тул хямд үнээр, ямар ч зардал гаргахгүйгээр газар дээр нь борлуулах нь тэдний хувьд ашигтай байна.²³

²² “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016”, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2017 он.

²³ “Үнэт металл, эрдэнийн чулууны олборлолт, үйлдвэрлэл, худалдааны өнөөгийн байдал”, Швейцарийн хөгжлийн агентлаг, Үнэт металлын сорьцын хяналтын газар.

Гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь нууц байдлаар явагддаг (ихэнх үйл ажиллагааг хууль бусаар болон албан бусаар эрхэлдэг), улирлын шинж чанартай (газар хөлдсөн үед олборлолт хийх боломжгүй) учраас уг үйл ажиллагааг эрхэлж буй иргэдийн тоог тодорхой гаргах боломжгүй байдаг. Энэ төрлийн үйл ажиллагаанд оролцогчдын тоо дулааны улиралд 30,000²⁴-100,000²⁵ хүрдэг гэсэн тооцоо, судалгаа байдаг. Гар аргаар ашигт малтмал олборлогчдын дийлэнх нь буюу 70 гаруй хувийг гар аргаар алт олборлогчид эзэлдэг²⁶. Сүүлийн жилүүдэд албан ёсны хэлбэрт шилжих хандлага гарч байгаа хэдий ч (2012-2015 оны хооронд албан бус гар аргаар алт олборлогчдын 11% нь албан ёсны нөхөрлөлийн хэлбэрт оржээ) хууль бус, албан бус алт олборлогчдын эзлэх хувь өндөр хэвээр байна.

Үндэсний статистикийн хороо, Швейцарийн хөгжлийн агентлагийн 2012 онд хийсэн тооцоогоор нэг гар аргаар алт олборлогч жилийн 4 ажиллаж, сард дунджаар 20 хоног ажиллаж, өдөрт дунджаар 0.4 гр алт олборлодог гэдгээс тооцож үзвэл нэг гар аргаар алт олборлогч сардаа 8.0 гр, жилдээ 32 гр алт олборлодог байна. Үүнийг дундын зуучлагчийн чадвар, аргачлалаас шалтгаалан 884 сорьцтой гэж тооцсон гэж үзвэл Монголбанкны 2020 оны 1 сарын 10-ны өдрийн ханшаар 3,862,333 төгрөг, АМНАТ хассаны дараа 3,669,216 төгрөг болж байна.

Сүүлийн жилүүдэд хувь хүмүүс чулууг тодорхой хэмжээгээр олборлон авч хууль бусаар хил гаргах, эсвэл албан ёсоор үйлдвэрлэл эрхлэх хандлага нэмэгдэж байна. Ялангуяа Улаанбаатар хот, Дорноговь аймгийн Сайншанд, Айраг сумдад, Өмнөговь аймагт албан ёсоор чулууны үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд нилээд олширч байна. Түүнчлэн гадаадаас ч зохих хэмжээгээр чулуу орж ирэх тохиолдол ч байна.²⁷

²⁴ Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага 2016

²⁵ Швейцарийн хөгжлийн агентлаг, 2015

²⁶ Швейцарийн хөгжлийн агентлаг, 2015

²⁷ “Үнэт металл, эрдэнийн чулууны олборлолт, үйлдвэрлэл, худалдааны өнөөгийн байдал”, Швейцарийн хөгжлийн агентлаг, Үнэт металлын сорьцын хяналтын газар.

Тухайлбал²⁸

Типологи жишээ #2: Г.Батмөнх: 700 кг үнэт чулууг УАЗ 69 машинд нуусан зөрчил илрүүлсэн. /Замын-Үүд дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга Г.Батмөнхтэй цаг үеийн асуудлаар ярилцлаа/

Энэ жилийн тухайд экспорт, импорт нийлсэн 600 гаруй зөрчил илрүүллээ. Экспорт дээр мах, хориглосон хязгаарласан ургамал, байгалийн чулуу, хориглож хязгаарласан түүхий эд гэх мэт олон тооны зөрчил илэрсэн. Хэмжээний хувьд хамгийн ихдээ 700 орчим кг чулууг 69 машины хаана хийж болох бүх газарт хийсэн байх жишээтэй. Үүнээс гадна 300-400 орчим кг чулуу ачсан хэд хэдэн тохиолдол илэрлээ. Махны хувьд хувь хүн биедээ авч явсан зөрчил гарсан. Биедээ 10-20 кг мах, төмөр зам дээр бол 80-600 кг мах нуун гаргах гэсэн 300 гаруй зөрчил илэрсэн. Энэ бүгдэд зөрчлийн хэрэг үүсгээд цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байгаа.

Бидний зүгээс хэрэг үүсгэж өгсөн зөрчлүүдийг маань хэрхэн шийдвэрлэж байгаа талаар прокурор, цагдаагийн байгууллагаас улиралд, жилдээ мэдээлэл авдаг. Чулуу болон махтай холбоотой асуудлууд бий. Чулуун дээр гэхэд хуулийн дагуу энгийн чулуу, үнэт чулуу гээд ангилдаг юм байна.

²⁸ “Г.Батмөнх: 700 кг үнэт чулууг УАЗ 69 машинд нуусан зөрчил илрүүлсэн”, 2019 оны 12 сарын 19.
<http://www.arslan.mn/social/news/611777.shtml>

5.2 Үнэт металл, үнэт чулууны дундын худалдан авагчид



Бага

Дунджаас доош

Дунджаас дээш

Өндөр

Алтны борлуулалтын сүлжээнд дундын худалдан авагчдыг орон нутгийн алтны ченж (3), Улаанбаатар дахь алтны ченж (6), алт олборлогч аж ахуйн нэгжийн алтыг Үнэт металл сорьцын хяналтын газарт сорьц тогтоолгон Монголбанкинд болон арилжааны банкинд тушаахад оролцож буй иргэд (5) бүрдүүлж байна. Албан бус сүлжээний хувьд Улаанбаатар дахь алтны ченжээс гадна алтыг хууль бусаар хил нэвтрүүлэхэд оролцож буй этгээд, бүлэглэлийг энд авч үзэх шаардлагатай.

Зураг 8: Алт борлуулалтын сүлжээ



Эх үүсвэр: Монголбанк.

Монголбанкинд 2020 онд... иргэн, кг алт тушаасан бол ... аж ахуйн нэгж, кг алт тушаажээ.

Зураг 5-д үзүүлсэн Алт борлуулалтын сүлжээнд улаанаар тэмдэглэгдсэн албан бус сүлжээний хувьд голчлон бэлэн мөнгөөр худалдаа хийгдэж байгаа учраас эдгээр сүлжээн дэх гүйлгээний талаарх мэдээлэл, гүйлгээний дундаж хэмжээ зэргийн талаар илүү нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай.

Нэг алтны ченж хэдий хэмжээний алтыг худалдан авч байгаа талаарх мэдээллийг доорх жишээнээс харж болно.

“Найман шарга” төв буюу валютын хар зах дээр компаниуд хувь хүний нэрээр алт тушаах явдал газар авчээ. Энд 10 гаруй ченж алт авч байна. Тэд Монголбанкны албан ханшаас 1000-2000 төгрөгөөр хямд авдаг ч явдал, чирээдэл бага тул иргэд, байгууллагууд алтаа зарах дуртай байдаг аж. “Найман шарга”-ын ойролцоо үнэт эдлэлийн ломбард ажиллуулахын зэрэгцээ алт худалдаж авдаг Б-тэй уулзахад “Өнгөрсөн жилтэй харьцуулахад компаниуд иргэний хувиар алт тушаах нь эрс нэмэгдсэн. Иргэд ихэнхдээ хэдэн зуун грамм, эсвэл цөөн кг-аар авчирдаг. Харин байгууллагууд 10 болон түүнээс дээш кг-ыг тушаадаг. Компаниуд их хэмжээний алт авчирч байгаа тул манайх өдөрт 10, сард 40 орчим кг алт авч байна. Өмнө нь долоо хоногт 10 кг хүрдээгүй байсан” гэлээ. Тэрбээр олон жил алтны ченж хийж буй тул үйлчлүүлэгчдээ анддаггүй аж. Тиймээс хэн нь компанийн өмнөөс алт зарж буйг түвэггүй ялгаж чаддаг гэдгээ нэмж хэлэв. Зөвхөн “Найман шарга” гэлтгүй алт худалдан авч буй Монголбанк болон бусад арилжааны банкуудад ч энэ үзэгдэл газар авчээ.²⁹

Татварын тухай хуулийн 17 дугаар бүлгийн 17.1 дэх заалтаар 45 кг алт буюу 3.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний борлуулалт хийсэн тохиолдолд 25 хувийн албан татвар төлдөг заалт байгаа нь алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн хувьд бичил уурхайчид, алтны зуучлагчдаар дамжуулан алтаа борлуулах сонирхолтой байгаа нь сөрөг үр дагаварыг бий болгож байна.³⁰

Үнэт металл, үнэт чулууг Сорьцын хяналтын байгууллагад бүртгүүлэх, Монголбанкинд худалдах тухай бүрт **холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэлийн үйл ажиллагаа хийгдэж байгаа учраас эдгээр шатанд харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх тохиолдолд энэ чиглэлд МУТС эрсдэл харьцангуй бага байна.**

Түүнчлэн **Монголбанк** нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болох 5 хувийг суутган, **алтны үнийг тухай бүр иргэн, аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлдэг.**

Алтны борлуулалтын сүлжээнээс харахад хууль бусаар олборлосон алтыг албан бус сүлжээгээр дамжуулан **дундын зуучлагчид Монголбанкинд тушаах** эсвэл **хууль бусаар хил давуулан борлуулах** арга зам байна.

Хууль бусаар олборлосон алтыг борлуулах шатанд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Монголбанкинд иргэд, аж ахуйн нэгжээс алт худалдан авч байгаа үйл ажиллагаан дахь бүртгэл, хяналтыг сайжруулах замаар **дундын худалдан авагчид (ченжүүд), тэдний хөрөнгийн эх үүсвэр, худалдан авсан алтны гарал үүсэлд тавих хяналтыг бий болгох.**

²⁹ “Хуулийн цоорхойгоор “гоожиж” буй шар металл”, Б.Баярмаа, ЗГМ, 2017 оны 08 сарын 31.

<https://www.ubinfo.mn/read/7151>

³⁰ “Бичил уурхайгаар олборлосон алтны нийлүүлэлтийн сүлжээ, түүний макро эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, бодлогын санал, зөвлөмж”, Гүйцэтгэсэн: Монголын Экспортлогчдын Холбоо, Тогтвортой бичил уурхай төсөл.

- Тагнуулын байгууллага, гаалийн байгууллага зэрэг хууль хяналтын байгууллага дахь **алт хууль бусаар хил давуулах гэмт хэргийн мэдээлэл, судалгаанд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.**

Тиймээс Монголбанк алт тушааж буй иргэдийн хувьд дараахь зүйлсийг тодруулж, харилцагчийг таньж мэдэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.

1. Улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлсон улсын иргэн болон ААНБ, НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, бүлэг нэгдэл эсэх.
2. Өндөр болон дундаж эрсдэлтэй гэж тодорхойлсон суурь гэмт хэрэгт холбогдож байсан эсэх эсвэл тэдгээртэй холбоотой ажил, үйл ажиллагаа эрхэлдэг эсэх.
3. Алт тушаагч иргэний эрхэлж буй ажил, үйл ажиллагааны чиглэл алтны арилжаатай холбоотой эсэх.
4. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны олборлолт хийж буй аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгч, хамаарал бүхий этгээд эсэх.
5. Тушааж буй алтны гарал үүсэл буюу аль уурхайгаас хэн олборлосон болохыг тодруулах.
6. Огцом өөрчлөгдсөн өндөр дүнтэй эсвэл анх удаа гүйлгээ хийж байгаа гэх мэт.

Түүнчлэн Үнэт металлын сорьцын хяналтын газар дээр алт арилжаалагч иргэдэд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой. Сорьц тогтоолгож буй алтны үнийн дүн 20.0 сая төгрөг болон түүнээс бол харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, энэ талаарх мэдээллийг СМА болон СЗХ-нд хүргүүлдэг журмыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай. Үнэт металлын сорьцын хяналтын газрын мэдээллээр 2019 оны эхний 10 сарын байдлаар алт арилжаалагч 143 иргэн үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах үйлчилгээг үзүүлсэн байна.

Иргэд болон аж ахуйн нэгжүүд Монголбанкинд шууд тушаахгүйгээр дундын худалдан авагчид ченжүүдэд хандах болсон, энэ төрлийн бизнес өргөжиж байгаа нь алт тушаалтын үйл явц дахь шат дараалалтай холбоотой гэсэн хэвлэлийн мэдээ, сурвалжлага байгааг анхаарч үзэх шаардлагатай.

Алтаа Сорьцын хяналтын албаар баталгаажуулан Монголбанкинд тушаахад 1-2 хоног шаардагддаг нь хөдөө орон нутгаас ирж буй иргэдэд хүндрэлтэй байдаг, мөн сорьцын хяналтын алба баталгаажуулж байгаа алтнаас дээж авдаг учир багахан хэмжээний алт баталгаажуулахад ихэнх нь тэндээ шингээд алга болчихдог нь банкыг бус ченжийг сонгох нөхцлийг бүрдүүлдэг байна. "Алтаа зарж байгаа хүмүүс түргэн шуурхай үйлчилгээ, үнийн уян хатан бодлого, санхүүгийн дэмжлэгийг гол шалгуураа болгодог юм шиг санагддаг. Ченжүүд алтаа тушааж байгаа хүмүүст ямар нэгэн шаардлага тавьдаггүй, хайлуулалтын хувьд хорогдол маш бага. Сорьцыг усан жингийн аргаар гаргадаг нь сорьцын хяналтын албаны сорьцоос нэг их зөрдөггүй зэрэг нь ченжүүдийг сонгох шалтгаан болдог байна".³¹

³¹ "Сурвалжлага: Алтны олборлолтод улайрах бус авдарлах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна"
<http://www.24tsag.mn/a/156453>

Энэхүү албан бус алтны наймааг дагаад хулгай, дээрмийн гэмт хэргүүд гарах талтай.³²

Типологи жишээ #3: Алтны ченжээс алтан гулдмайг нь дээрэмджээ.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны “Баянмонгол” хороололд оршин суудаг алтны ченж 37 настай, иргэн Д-г өнгөрсөн ням гаригийн (2016 оны 3 сарын 13) шөнө дээрэмдсэн хэрэг гарчээ. Дээрэмчид ченжийг зодоод цүнхийг нь булаан зугтсан аж. Цүнхэнд нь цамцанд ороож боосон тамхины хайрцагны хэмжээтэй 1,841.66 грамм хоёр ширхэг алтан гулдмай байсан нь анхаарал татна. Дээрэмдсэн этгээдүүд нь 25 орчим настай, 170-175 см орчим өндөртэй, гонзгой царайтай, хар хувцастай байсныг цагдаагийнханд дүрслэн мэдээлэл өгөөд байгаа юм.

Алтан гулдмай нь Монголбанкны ханшаар буюу нэг грамм алт 80 орчим мянган төгрөг гээд бодохоор нийт 150 орчим сая төгрөгийн үнэд хүрэхээр. Уг газар нь азаар камертай байсан тул гэмт этгээдүүдийн царай тод бичигджээ. Энэхүү хэргийг Баянзүрх дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст шалгаж, сэжигтэй гэмт этгээдүүдийг эрэн сурвалжилж байна.

³² Ж.Батсайхан, Эх сурвалж: "Монцамэ" агентлаг, <http://www.sonin.mn/news/gemt-herег/58762>

5.3. Үнэт чулуу зүсэх, өнгөлөх болон үнэт металл цэвэршүүлэх үйлчилгээ эрхлэгчид



Үнэт чулуу зүсэх, өнгөлөх үйлчилгээ эрхлэгчид. Үнэт чулууны дархан буюу үнэт чулуу зүсэх өнгөлөх мэргэжлийн хүн Монголд маш цөөн, тухайлбал, алмааз зүсч талсжуулах мэргэжилтэй нэг хүн байдаг.³³

Монголчууд хэдийгээр үнэт чулуун эдлэл, хэрэглэлийг амьдрал ахуйдаа хэрэглэж ирсэн уламжлалтай хэдий ч орчин цагийн Монголчуудын хувьд үнэт чулууны талаарх мэдлэг ойлголт бага гэж үздэг байна. Монгол Улсад үнэт чулууны олборлолт хийгддэггүй учраас үнэт эдлэл, гоёл чимэглэлийн зориулалтаар үнэт чулууг бусад улс орноос бага хэмжээгээр импортоор оруулж ирдэг байна.

Үнэт чулуу зүсэх, өнгөлөх үйлчилгээ эрхлэгчдийн хувьд үнэт эдлэл, гоёл чимэглэлийн зүйлсийн шигтгээ бэлтгэх, хөөрөг урлах зэрэг үйлчилгээг голчлон үзүүлдэг байна.

Энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгчдийн тоо харьцангуй цөөн, боловсруулалт хийх үнэт чулуу төдийлөн элбэг бус үнэт чулууны талаарх олон нийтийн мэдлэг ойлголт харьцангуй доогуур байгаа, үнэт чулуугаа өөрсдөө худалдаж аваад бэлэн бүтээгдэхүүн болгож зарах үйл ажиллагааг эрхэлдэггүй зэргээс үзэхэд энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд МУТСТ эрсдэлд шууд өртөх магадлалтай багатай гэж үнэлж болохоор байна.

Гэхдээ **Мэргэжлийн хяналтын байгууллага, стандарт, хэмжил зүйн байгууллага болон холбогдох бусад төрийн байгууллагатай хамтран эдгээр хүмүүсийг бүртгэж, мэргэжлийн зэрэг тогтоох, уг үйлчилгээний стандартыг тогтоох зэргээр зохицуулалтад оруулахаас гадна МУТС эрсдэлийн талаарх мэдлэг, ойлголтыг өгч байх нь зүйтэй.**

Үнэт металл хайлах үйлчилгээ эрхлэгчид. Үндсэн болон шороон ордоос ялгаж авсан алтыг тусгай зориулалтын төхөөрөмжөөр хайлж гулдмайлдаг. Алт хайлах төхөөрөмж нь индукцийн болон цахилгаан зуух байхаас гадна өндөр температурт ажиллах боломжтой хийн дөл /хийн баллон/-өөр хайлж болно. Өнөөдөр Монгол Улсад үндсэн орд ашиглаж байгаа Бороо гоулд, Баян – Айраг, Олон овоот зэрэг компаниуд өөртөө алт ялгах, хайлах төхөөрөмжтэй бөгөөд бусад уурхайнууд, иргэдийн олборлосон алтыг зөвхөн Стандарт, хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын хяналтын газарт төвлөрүүлэн хайлж гулдмайлж байна.³⁴ Монгол Улсад хайлсан алтан гулдмайн хэмжээ 12.5 кг /400 унци/-аас ихгүй байх эрх зүйн зохицуулалттай.

³³ <https://www.n24.mn/a/1872>

³⁴ “Үнэт металл, эрдэнийн чулууны олборлолт, үйлдвэрлэл, худалдааны өнөөгийн байдал”, Швейцарийн хөгжлийн агентлаг, Үнэт металлын сорьцын хяналтын газар.

Манай улсад бичил уурхайгаар олборлосон үндсэн ордын хүдрийг мөнгөн усгүй технологи буюу хүндийн жингийн (гравитацийн) аргаар баяжуулах технологи бүхий төвлөрсөн баяжуулах цехүүдэд баяжуулдаг. Ийм цех Төв аймгийн Борнуур, Сэлэнгэ аймгийн Мандал болон Баянхонгор аймгийн Баян-Овоо сумдад байдаг.³⁵

Швейцарийн хөгжлийн агентлагын Тогтвортой бичил уурхай төслийн дэмжлэгтэйгээр бичил уурхайчдын үүсгэн ХАМО ХХК Төв аймгийн Борнуур суманд Алт баяжуулах цехийг 2009 онд ашиглалтад оруулжээ. Уг баяжуулах цехээр Бичил уурхайчдын холбоо ТББ-ын гишүүн 260 бичил уурхай эрхлэгчдээс гадна Төв, Сэлэнгэ, Булган, Баянхонгор, Өмнөговь, Хэнтий зэрэг аймгийн хувиараа ашигт малтмал олборлогчид үйлчлүүлж байна.³⁶

Уг цехэд алтны хүдрийг бутлах, нунтаглах, баяжлуулах, гүйцээн баяжуулах, цэвэршүүлэх шат дамжлагаар болосвруулсны дараа хийн хайлуулагчаар хайлуулан товч хэлбэртэй хайлуулсан алтыг гаргаж өгдөг байна.

Эдгээр цехүүдээр үйлчлүүлэгчдийн холбогдох мэдээллийг бүртгэж авч мэдээллийн сан бүрдүүлэх нь цаашид тухайн алтны хөдөлгөөнийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Үнэт металлын сорьцын хяналтын газрын хайлан цехэд Алтыг хайлж гулдмайлахдаа:

- Хайлах цехийн ажилтан алтыг хүлээн авч алтны эзнийг байлцуулан жинлэж тэмдэглэл хөтөлсөний дараа алтыг хайлж, гулдмайлах ажлыг гүйцэтгэх бөгөөд бэлэн болсон алтан гулдмайг дахин жинлэж, акт бичиж өгнө.
- Алтан гулдмай дээр тухайн алтан гулдмайн дугаар, Сорьцын хяналтын газрын таних тэмдгийг цохиж өгдөг.
- Хайлж гулдмайлах ажлыг хийж дууссаны дараа хайлах цехийн ажилтан дараах мэдээллийг агуулсан баримтыг бичиж бэлэн болсон алтан гулдмай болон хайлуулалтаас гарсан хаягдлын хамтаар алтны эзэнд өгнө. Үүнд: алтыг хайлуулахын өмнөх болох дараах жин, хайлуулалтаас гарсан хаягдлын (шаарны) жин, хайлуулалтаас үүссэн хорогдлын (ууршилтын) хэмжээ зэрэг орно.
- Хайлах цехэд нэг грамм алт хайлсны хөлс 50 төгрөг байдаг.

Хайлах цехэд тухайн алтан гулдмайн дугаарыг харилцагчийн (алтны эзний) холбогдох мэдээлэлтэй бүртгэж авч мэдээллийн сан бүрдүүлэх нь цаашид тухайн алтны хөдөлгөөнийг хянахад чухал ач холбогдолтой байна.

Монгол Улс ОХУ, Их Британи, Япон зэрэг улсад алтаа цэвэршүүлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд Швейцарь улсад цэвэршүүлж байна. Гадаадад цэвэршүүлж байгаа алтны тээвэр, даатгал, хамгаалалтын зардал өндөр гардаг. Мөн Монгол Улсын олборлон баяжуулж байгаа алт нь дунджаар 85.0 хувийн агуулгатай бөгөөд түүнийг олон улсын зах зээлд борлуулахын тулд 99.99 хувийн цэвэр алт болгох шаардлагатай байдаг.³⁷

³⁵ “Бичил уурхайгаар олборлосон алтыг боловсруулах, албан ёсны сүлжээгээр худалдаалах арга зам”, Швейцарийн хөгжлийн агентлаг, Тогтвортой бичил уурхай төсөл, Сорьцын хяналтын газар

³⁶ “Борнуур суманд дахь мөнгөн усгүй технологи бүхий алтны хүдэр баяжуулах цехийн танилцуулга”, Швейцарийн хөгжлийн агентлаг, Тогтвортой бичил уурхай төсөл, Эрдэс баялаг, эрчим хүчний яам. 2011 он.

³⁷ Ашигт малтмал, газрын тосны газар - <https://www.mrpam.gov.mn/news/127/>

Монгол Улсын төрөөс Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулах төслийг 2017 оноос эхлүүлээд ажиллаж байна.

5.4. Үнэт эдлэл үйлдвэрлэгчид



Үнэт металлын сорьцын хяналтын газрын нэг үндсэн үүрэг нь үнэт металл тэдгээрээр үйлдвэрлэсэн гоёл чимэглэлийн эдлэлд сорьцын баталгааны тэмдэг дарж өгдөг. Үнэт металлын сорьцын хяналтын газрын мэдээллээр 2019 оны эхний 10 сарын байдлаар гоёл чимэглэлийн үйлдвэрлэл эрхлэгч нийт 77 иргэн, аж ахуйн нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ сорьцын баталгаажуулалт хийсний 19 нь аж ахуйн нэгж, 58 нь иргэд байжээ. Тус газрын мэдээллээр улсын хэмжээнд нийтдээ 150 гаруй үнэт эдлэл үйлдвэрлэгч байдаг гэсэн мэдээлэл байна. Үнэт металлын сорьцын хяналтын газраас үйлдвэрлэгчдэд зөвхөн өөрийнхөө барааны тэмдэг тавьсан байх ёстой гэсэн ганц шаардлага тавьдаг бөгөөд жилдээ 300,000 орчим үнэт эдлэлийг баталгаажуулж байна.³⁸ Үнэт эдлэлийн Сорьцын баталгааны талаарх танилцуулга, үйлчилгээний хөлсний талаарх мэдээллийг Хавсралт 4-өөс үзнэ үү.

Стандарт, хэмжил зүйн газар Түмэн эрдэнэс Үнэт эдлэл үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран “MNS 6505 – 2015: Мөнгөн аяга. Ерөнхий шаардлага стандарт”-ыг батлуулан мөнгөн аяга үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэд тус стандартын дагуу үйлдвэрлэл явуулж үнэт эдлэл худалдан борлуулах цэгүүд, иргэдэд сурталчлах үйл ажиллагааг явуулж байна.³⁹

Түүнчлэн “Үнэт металл, эрдэнийн чулуугаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5565:2005” стандартын шаардлагыг энэ төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд тавьдаг бөгөөд стандартын хэрэгжилтэд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Стандарт хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажилтын хэлтэс, сорьцын хяналтын хэлтэс, “Түмэн эрдэнэс” мэргэжлийн холбоо зэрэг байгууллагууд хяналт шалгалт хийдэг байна. Тухайлбал:

³⁸ “Үнэт металл, эрдэнийн чулууны олборлолт, үйлдвэрлэл, худалдааны өнөөгийн байдал”, Швейцарийн хөгжлийн агентлаг, Үнэт металлын сорьцын хяналтын газар.

³⁹ Стандарт хэмжил зүйн газар, Үнэт металлын сорьцын хяналтын газар. <https://masm.gov.mn/masmi/түмэн-эрдэнэс-холбоо/>

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Стандарт хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажилтын хэлтэс, сорьцын хяналтын хэлтэс, “Түмэн эрдэнэс” мэргэжлийн холбоотой хамтарсан удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үнэт эдлэл үйлдвэрлэл, алт мөнгөний дарханы үйл ажиллагаанд шалгалт хийлээ.

Энэ удаагийн түвшин тогтоох шалгалтыг “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ, үнэт металл эрдэнийн чулуугаар үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд тавих ерөнхий шаардлага” MNS 5565:2005 стандарт, “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор явуулсан аж. Дүүргийн хэмжээнд үнэт металл, алт мөнгөний дарханы чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зургаан үйлдвэрлэл, таван алт мөнгөний дархан шалгалтад хамрагдсанаас найм нь хэвийн, гурав нь үйл ажиллагаагаа түр зогсоосон байна. Түүнчлэн шалгалтын явцад үнэт эдлэл, алт мөнгөний дарханы газруудын 45 хувь нь түрээсийн байранд 55 хувь нь өөрийн гэсэн ажлын байртай байгааг тогтоожээ. Харин шалгалтад хамрагдсан газруудын 25 хувь нь бүрэн хангалттай, 75 хувь нь хангалттай гэсэн дүн авчээ.⁴⁰

Хэрэглэгчдийн зүгээс худалдаалагдаж буй үнэт эдлэлийн жинхэнэ эсэх, сорьцын талаар гомдол мэдээлэл гарах болсон, Засгийн газраас Сорьцын хяналтын дүрэм батлан гаргасантай холбоотойгоор 2010 оноос эхлэн үнэт эдлэл үйлдвэрлэгч, борлуулагч нарын худалдан борлуулж буй үнэт эдлэлд сорьцын шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж, хэрэглэгчдийн энэ чиглэлийн мэдээлэл сурталчилгааг тодорхой хэмжээнд хийж ирсэн. Тухайн үеийн мэдээллээс харахад импортын үнэт эдлэлийн хувьд гарч буй зөрчилтэй харьцуулахад дотоодын үйлдвэрлэгчдийн сорьцын зөрчил харьцангуй бага байжээ. Дотоодын үнэт эдлэл үйлдвэрлэгчид хяналт зохицуулалт болон хэрэглэгчдийн шаардлагын дагуу үйлдвэрлэсэн үнэт эдлэлээ Үнэт металлын сорьцын хяналтын газраар сорьцын баталгаажуулалт хийлгэх хандлага харьцангуй нэмэгдэж байна.

Тиймээс **Сорьцын хяналтын газраар дамжуулан сорьцын баталгааг хийх үед үнэт эдлэл түс бүрээр, ялангуяа 20.0 сая төгрөг болон түүнээс дээш үнэлгээтэй үнэт эдлэл түс бүрийн мэдээллийг бүртгэж авч мэдээллийн сан бүрдүүлэх нь цаашид тухайн үнэт эдлэлийн хөдөлгөөнийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.**

Түүнчлэн Стандарт, хэмжил зүйн газар, Түмэн эрдэнэс Үнэт эдлэл үйлдвэрлэгчдийн холбоо болон бусад мэргэжлийн холбоотой хамтран **үнэт эдлэл үйлдвэрлэгчдийн дунд МУТС-ээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай.**

Өмнөх 5.2 дугаар бүлгийн Зураг 6-д харуулсан Алт борлуулалтын сүлжээний хууль бус борлуулалтын сүлжээний эцсийн худалдан авагчдын нэг нь алт мөнгөний дархан – үнэт эдлэл үйлдвэрлэгчид болж байна. Өндөр татвартай, улсын нөөцийг бүрдүүлэхээс бус худалдан борлуулах үүрэг хүлээдэггүй учраас үнэт эдлэл үйлдвэрлэгчид Монголбанкнаас

⁴⁰ “Үнэт эдлэлийн үйлдвэрлэлд шалгалт хийжээ”, Монголын Үндэсний Телевиз. 2014 оны 6 сарын 13.
<http://www.mnb.mn/i/26036>

алтыг ховорхон худалдан авдаг байна. Тиймээс үнэт эдлэл үйлдвэрлэгчид зөвхөн алтны ченжүүдийг голчлон үнэт металл, үнэт чулууг худалдан авдаг бөгөөд худалдан авсан алт, үнэт металл, үнэт чулууны эх үүсвэрийг шалгадаггүй байна⁴¹.

Иймээс үнэт эдлэл үйлдвэрлэгчдийн дунд МУТС-ээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд харилцагчийг таньж мэдэх, худалдан авч буй үнэт металл, үнэт чулууны гарал үүслийг шалгах зөвлөмжийг өгч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Нөгөө талаар **хэрэглэгчдийн дунд үнэт металлын сорьцын баталгаа, эрдэнийн чулууны гэрчилгээ, үнэт эдлэлийн гарал үүслийг нягталж худалдан авалт хийж, хуурамч бүтээгдэхүүн худалдан авч хөрөнгө санхүүгийн алдагдал хүлээхээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл сурталчилгааны ажлыг хэрэгжүүлснээр хэрэглэгчдийн мэдлэг, ойлголт, хандлага өөрчлөгдөж, үйлдвэрлэгч, борлуулагчдаас үнэт металлын сорьцын баталгаа, эрдэнийн чулууны гэрчилгээ, үнэт эдлэлийн гарал үүслийн талаарх мэдээллийг шаардах болно.**

Ингэснээр Сорьцын хяналтын дүрмийн хэрэгжилт сайжирч, үйлдвэрлэгч, борлуулагчид Сорьцын хяналтын газарт хандаж сорьцын баталгаа, гэрчилгээ авах хандлага нэмэгдэж, энэ төрлийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж тавигдана.

5.5. Үнэт эдлэлийн жижиглэн худалдаа эрхлэгчид



Сорьцын хяналтын газрын мэдээллээр үнэт эдлэлийн жижиглэн худалдаа эрхлэгч 300 гаруй иргэн байдаг. Үнэт эдлэлийн жижиглэн худалдаа эрхлэгчдийн хувьд дараахь 2 бүлэгт ангилж болно.

1. Дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн үнэт эдлэлийг худалдан борлуулах салбар, дэлгүүр, лангуу, орон нутаг дахь борлуулагчид;
2. Импортоор үнэт эдлэл оруулж ирж дэлгүүр, лангуу, онлайн худалдаагаар худалдан борлуулагчид.


Дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэж борлуулсан үнэт эдлэлийн нийт үнийн дүнгийн талаарх тодорхой статистик мэдээлэл олдоогүй болно. Ерөнхий ажиглалт, мэдээлэлд

⁴¹ "A Rapid Assessment of Gold and Financial Flows linked to Artisanal and Small-Scale Gold Mining in Mongolia: Follow the Money: Mongolia", UNIDO, The Global Initiative Against Transnational Organized Crime, Levin Resources, GEF, October 2017

үндэслэн дүгнэж үзэхэд үнэт эдлэлийн нийт борлуулалтын дүнд импортын үнэт эдлэлийн эзлэх хувийн жин өндөр байна.

Үнэт эдлэлийн импорт: Монгол Улс 2018 онд 2.4 сая ам.долларын үнэт эсвэл хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлан бүрмэл үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлсийг импортолжээ. Энэ нь тухайн онд хийгдсэн нийт импортын 0.04%-ийг эзэлж байжээ (2000-2018 онд хийгдсэн нийт импортын 0.01-0.05%-ийг эзэлж байжээ).

Зураг 9: Үнэт эсвэл хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлан бүрмэл үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлсийн импортын хэмжээ, мян.ам.доллар



Гаалийн ерөнхий газрын Статистикийн хэлтсийн мэдээллээр 2018 оноос 2019 оны 10 сарын 31 хүртэлх хугацаанд БТКУС-ийн ангиллын 71 дүгээр бүлэг буюу Жинхэнэ эсвэл таримал сувд, үнэт эсвэл хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлан бүрмэл үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлст хамаарах 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий барааны импортын гаалийн мэдүүлэг 28 бүртгэгджээ. Эдгээр мэдүүлэгийн:

- 11 нь Монголбанкны оруулж ирсэн мөнгөн зоос, зоосон мөнгөн тэмдэгт, зэс зоосны;
- 8 нь аж ахуйн нэгжүүдийн Тайланд, Хонгконг, Дани, Итали улсаас импортолсон гоёлын дуураймал хүзүүний зүүлт, хүзүү, гарны гоёл чимэглэл, мөнгөн бугуйвчны зүүлт болон цагаан алтан бөгжний;
- 3 нь иргэний Турк, Сингапур, Швейцари улсаас оруулж ирсэн алтан ээмэг, алтан гинж, цуглуулгын зоосны;

- 4 нь сүлжээний бизнес эрхэлдэг гадаадын хөрөнгө оруулалттай компанийн АНУ-аас оруулж ирсэн гишүүн, шилдэг борлуулагч, менежер, захирлын тэмдэг, энгэрийн зүүлтний;
- 1 нь Цагдаагийн ерөнхий газрын БНХАУ-аас оруулж ирсэн цолны тэмдэгийн;
- 1 нь "500" гэсэн горимтой иргэний БНХАУ руу гаргахаар ОХУ-аас оруулж ирсэн байгалийн ногоон хаш чулууны мэдүүлэг тус тус байжээ.

Дээрх мэдээлэлд үндэслэн жижиглэн худалдаалах зорилгоор импортоор оруулж ирсэн үнэт эдлэлийн дундаж үнийн мэдээллийг гаргахад дараахь байдалтай байна.

Хүснэгт 2: Импортоор орж ирсэн 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий үнэт эдлэлийн нэгжийн үнэ

Үнэт эдлэлийн төрөл, тодорхойлолт	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ, төгрөг
585 сорьцтой, таримал сувд, бадмаараг, цагаан циркон шигтгээтэй гоёлын алтан ээмэг	хос	134,458
Гоёлын дуураймал, ган материалтай, шигтгээтэй болон шигтгээгүй хүзүүний зүүлт	ширхэг	70,958
Өнгө өнгийн, төрөл бүрийн гоёмсон хэлбэртэй, шигтгээтэй болон шигтгээгүй эмэгтэй хүний хүзүү гарны гоёл чимэглэл	ширхэг	15,114
26 төрлийн загвартай, мөнгөн, сорьц S170, цагирган хэлбэртэй циркон шигтгээтэй, эмэгтэй бугуйвчны зүүлт	ширхэг	98,806
925 сорьцтой мөнгөн, цагирган хэлбэртэй циркон шигтгээтэй, эмэгтэй бугуйвчны зүүлт	ширхэг	61,698
916 сорьцтой, шигтгээгүй, алтан гинж	ширхэг	249,366
750К сорьцтой, 0.41ct алмаазан шигтгээтэй, цагаан алт 9.8 гр, ягаан индранил - 3.08 гр, 13 размерын, эмэгтэй загварын цагаан алтан бөгж	ширхэг	21,428,077
диаметр нь 65 мм, хувийн цуглуулганд, хайрцагтай, мөнгөн 0.999 сорьцтой, 2000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, үлэг гүрвэлийн дүрстэй, зоосны жин 1x0.0933гр, хайрцаг нь 1x0.2506гр, цуглуулгын зоос	ширхэг	505,182

Үйл ажиллагааны зохицуулалт: Үнэт эдлэлийн жижиглэн Алмааз, үнэт эдлэл, үнэт металлын арилжаа эрхлэгчдийн хувьд хулгай болон залилангийн эрсдэлүүд тулгардаг учраас эрсдэлийн үнэлгээ тэдний хувьд харьцангуй танил зүйл байдаг. МУТС эрсдэл нь салбарын эдгээр уламжлалт асуудалд, илүү албан ёсны бүтэцтэй хөтөлбөрүүдэд тусгалаа олсон байх хэрэгтэй. Тухайлбал, алмаазны арилжаа эрхлэгчид байгалийн алмаазны санхүүгийн зөрчлийг эрсдэлийг бууруулахад чиглэсэн дэлхий нийтийн Кимберлейн процесс (Kimberley Process⁴²) хөтөлбөрийн талаар мэдлэгтэй байдаг.⁴³ Үүнийг дурдахын учир нь

⁴² <https://www.kimberleyprocess.com/>

⁴³ Paragraph 15. "RBA Guidance for Dealers in Precious Metal and Stones", FATF/OECD, 17 June, 2018

эдгээр олон улсын зохицуулалт, хөтөлбөрт нэгдэн орох замаар үнэт эдлэл, үнэт чулууны арилжааны хяналтыг хэрэгжүүлэх боломжийг анхааралдаа авах шаардлагатай.

Манай орны хувьд төвлөрсөн хяналтын тогтолцоотой орнуудын нэгэн адил бүтэц зохион байгуулалттай учир Сорьцын хяналтын газрын Үнэт металлын сорьц тогтоох лабораторид нэгдсэн журмаар сорьцын баталгааны тэмдэг дарж үнэт эдлэлийг баталгаажуулж байна. Манай улсад олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх албан ёсны сорьцын баталгааны тэмдэгтэй үнэт эдлэл импортоор бараг орж ирэхгүй байгаа бөгөөд ганзгын наймаачдын оруулж ирсэн үнэт эдлэлүүд нь үйлдвэрлэгчийн барааны тэмдэггүй, зөвхөн сорьцын цэврийн цифр дарагдсан байдаг тул хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс тэдгээрийг Үнэт металлын сорьц тогтоох лабораторид байнга шалгадаг. Шалгалтаар зохих сорьцдоо хүрч байвал өөрийн сорьцын баталгааны тэмдэг дарж баталгаажуулдаг. Сорьцын цифртээ хүрэхгүй тохиолдолд хамгийн ойр байгаа доод сорьцоор баталгаажуулах, эсвэл Монгол Улсад худалдан борлуулж болохгүй гэсэн шаардлага тавьж буцаадаг.⁴⁴

Тиймээс **Сорьцын хяналтын газраар дамжуулан сорьцын баталгааг хийх үед үнэт эдлэл тус бүрээр, ялангуяа 20.0 сая төгрөг болон түүнээс дээш үнэлгээтэй үнэт эдлэл тус бүрийн мэдээллийг бүртгэж авч мэдээллийн сан бүрдүүлэх нь цаашид тухайн үнэт эдлэлийн хөдөлгөөнийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.**

Түүнчлэн Стандарт, хэмжил зүйн газар болон холбогдох бусад хууль хяналтын байгууллагатай хамтран **үнэт эдлэлийн жижиглэн худалдаа эрхлэгчдийн дунд МУТС-ээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай.**

Нөгөө талаар **хэрэглэгчдийн дунд үнэт металлын сорьцын баталгаа, эрдэнийн чулууны гэрчилгээ, үнэт эдлэлийн гарал үүслийг нягталж худалдан авалт хийж, хуурамч бүтээгдэхүүн худалдан авч хөрөнгө санхүүгийн алдагдал хүлээхээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл сурталчилгааны ажлыг хэрэгжүүлснээр хэрэглэгчдийн мэдлэг, ойлголт, хандлага өөрчлөгдөж, үйлдвэрлэгч, борлуулагчдаас үнэт металлын сорьцын баталгаа, эрдэнийн чулууны гэрчилгээ, үнэт эдлэлийн гарал үүслийн талаарх мэдээллийг шаардах болно.**

Ингэснээр Сорьцын хяналтын дүрмийн хэрэгжилт сайжирч, үнэт эдлэлийн жижиглэн худалдаа эрхлэгчдийн хувьд Сорьцын хяналтын газарт хандаж сорьцын баталгаа, гэрчилгээ авах хандлага нэмэгдэж, энэ төрлийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж тавигдана.

⁴⁴ “Үнэт эдлэлийн сорьцын баталгааны тэмдэг, түүний ач холбогдол”, СХЗГ-ын Сорьцын хяналтын хэлтсийн Улсын байцаагч Ш. Бямбасүрэн, 2017 оны 4 сарын 17. <http://www.bestnews.mn/r/3774>

5.6. Үнэт эдлэлийн хоёрдогч зах зээл дээрх худалдан авагчид, худалдан борлуулагчид



Энд хуучин үнэт эдлэл худалдан авч дамжуулан борлуулагчид, эртний эдлэл худалдан авч дамжуулан борлуулагчид болон эртний эдлэлийн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг хамруулж авч үзэж болох юм.

Хуучин үнэт эдлэл худалдан авч дамжуулан борлуулагчид, эртний эдлэл худалдан авч дамжуулан борлуулагчдын хувьд соёлын биет өвийг хууль бусаар олж авч, борлуулах, хил давуулах суурь гэмт хэрэгтэй холбоотой үйлдэлд холбогдох эрсдэлтэй байна.

Эртний эдлэлийн дэлгүүрийн эзэд соёлын биет өвийг хууль бусаар олж авч, борлуулдаг болох нь цагдаад өгсөн гэмт хэрэгтнүүдийн мэдүүлгээс харагдаж байна. Тухайлбал, 2017 онд эртний эдлэлийн дэлгүүр ажиллуулдаг Ж гэгч 32 нэр төрөл бүхий 84 ширхэг эртний үнэт эдлэл, түүхийн олдвор хилээр гаргах гэж байгаад баригджээ. Тэрбээр нийслэлд эртний эдлэлийн дэлгүүр ажиллуулж байхдаа дээрх их хэмжээний эдлэлийг хуримтлуулсан гэж мэдүүлсэн байдаг. Мөн хилээр түүхийн үнэт эдлэл гаргах гэж байгаад баригдсан Ё гэгч түүхийн дурсгалд тооцогдох эд зүйлс, үнэт эдлэлүүдийг эртний эдлэлийн дэлгүүрээс авсан гэж мэдүүлжээ.

Албан бус мэдээллээр Монгол Улсын хэмжээнд эртний эдлэл зарж борлуулдаг 100 гаруй дэлгүүр байдаг бөгөөд үүний тал хувь нь нийслэлд үйл ажиллагаа явуулдаг гэсэн тоо байна. Гэхдээ эдгээрийн дийлэнх нь хуулбарласан болон энгийн хэрэглээний эд зүйлс худалдаалдаг байна. Харин жинхэнэ эртний эдлэлийн эх хувийг хөрөнгө чинээтэй эрхмүүдийн хүрээнд нууцаар наймаалдаг гэжээ⁴⁵.

Типологи жишээ #4: Шүүхээс 2010 онд Б.Энхбат нь Үндэсний түүхийн музейн сан хөмрөгийн эрхлэгчээр ажиллаж байхдаа 2004 оноос 2007 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд өөрийн итгэмжлэн хариуцаж байсан сан хөмрөгөөс удаа дараагийн үйлдлээр 410 дансны 1,004 ширхэг түүхийн үнэт үзмэр болох эд өлгийн зүйлийг хууль бусаар авч завшиж, үрэгдүүлэн 10 тэрбум 187 сая 291 мянган төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэнд тооцсон.

Гурван шатны шүүх хэргийг хэлэлцэж, Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар Б.Энхбатад 3 сая төгрөгийн эд хөрөнгө хурааж, 10 жил хорих ял оногдуулсан бөгөөд Өршөөлийн тухай хуульд зааснаар 3 жилийг өршөөн хасч биечлэн эдлэх ялыг 7 жил хорихоор тогтоожээ.

Хилээр гарч буй эртний эдлэлийн тодорхой хувь нь нэн эртний үед хамаарах эд зүйл байх нь олонтаа. Энэ хэрээр монголчуудын түүхийн үнэт өвийг хадгалж буй хиргисүүр, булш

⁴⁵ “Эртний ховор олдворын наймааг хянаж чадахгүй байна” 2019 оны 1 сарын 14.
<http://www.arслан.mn/social/news/599217.shtml>



бунхныг тонох хэрэг цөөнгүй гардаг тухай ШУА-ын Түүх, археологийн хүрээлэнгийн мэргэжилтэн ярьж байна. Манай улсын нутагт Хүннүгийн үеийн булш 10 мянга, хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр 7000, дөрвөлжин булш 3000 гаруй байдаг гэсэн тоо баримт бий. Гэтэл хиргисүүрийг тонож, үнэт эд зүйлийг цөлмөдөг бүлэглэл байдгийг мэргэжилтнүүд үгүйсгэхгүй байна. ШУА-аас зохион байгуулсан нэгэн хурал дээр 31 хиргисүүр булш тоногдсоны 29 нь орон нутгийн иргэдийн оролцоотой байсан гэдэг баримт ч бас байна.

Соёлын биет өвийг хилээр гаргах, хууль бусаар худалдан борлуулах гэж байгаад баригдсан этгээдэд хариуцлага тооцохын тулд тухайн олдвор, үнэт эдлэлийг шинжээчийн дүгнэлтэд тулгуурлах учиртай. Гэтэл эртний эдлэлийн мөн чанар, хамаарах хүрээг тогтоох зөвлөл дүгнэлтээ гаргаж чаддаггүйгээс хууль зөрчигчид ял завших тохиолдол гардаг байна. Мөн эртний эдлэлийн шинжээчийн чиглэлээр бэлтгэгдсэн боловсон хүчин манайд хомс байдаг нь ч нөлөөлдөг.

Иргэдийн гар дээр байгаа болон ченжүүдийн мэдэлд буй эртний эдлэл, үнэт зүйлсийн талаар бүртгэл мэдээлэл байдаггүй. **Хэрэв Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өмчлөгч нь эртний эдлэл, нэн ховор үнэт зүйлсээ бүртгүүлэх, худалдах, үзэсгэлэн гаргах заалтыг суулгаж өгснөөр энэ чиглэлд хяналт тавих боломжтой болно. Мөн цагдаагийн байгууллагад эртний эдлэл, хууль бус наймаагаар мэргэшсэн тасаг байгуулснаар эртний эдлэлийн дэлгүүрүүдийг хянах, хиргисүүр, булш тоногчдыг илрүүлэх, хуулийн хариуцлага хүлээлгэх боломж нэмэгдэнэ. Ингэснээр мөн авлигын гэмт хэргээс олсон хууль бус хөрөнгөө эртний эдлэл болгон хадгалдаг цагаан захтнуудын тоог хязгаарлах боломж бүрдэнэ.**

ХАВСРАЛТ 1. ЭРДЭНИЙН ЧУЛУУНЫ АНГИЛАЛ

Бүлэг	Хамаарах чулууны нэр (Монгол)	Олон улсын нэршил
1. Үнэт чулуу	Доржпалам	Diamond
	Маргад	Emerald
	Бадмаараг	Ruby
	Индраанил	Sapphire
	Сувд	Pearl
2. Хагас үнэт чулуу	Хувилгаан эрдэнэ	Alexandrite
	Улбар шар, ногоон, нил ягаан сапфир	Sapphire
	Эрдэнийн гэрэлт чимэд	Precious opal
	Эрдэнийн жадеит	Jadeite
	Демантоид	Demantoid
	Шпинель	Spinel
	Гэрэлт чимэд	Opal
	Усан биндэръяа	Aquamarine
	Молор	Topaz
	Родолит	Rhodolite
	Галтмар	Tourmaline
	Хризолит	Peridot
	Циркон	Zircon
	Биндэръяа	Beryl
	Кунцит	Kunzite
	Нил эрдэнэ	Amethyst
	Оюу	Turquoise
	Пироп	Pyrope
	Альмандин /анар/	Almandine
	Саран чулуу	Moonstone
Ногоон мана	Crysoprase	
Шаргал болор	Citrine	
Ягаан болор	Rose quartz	
3. Гоёл чимэглэлийн чулуу	Номин	Lapis lazuli
	Жадеит	Jadeite
	Хаш	Neprite
	Шүр	Coral
	Усан болор	Rock crustal
	Утаат болор	Smoky quartz
	Чариот	Charoite
	Мана, гартаам	Agat
	Амазонит	Amazonite
	Хув	Amber
	Хар мана	Onyx
	Үүрийн туяа	Rhodonite
	Гематит	Hematite
	Обсидан	Obsidan
	Ундрам	Aventurine
	Барын нүд	Tiger's eye
Муурын нүд	Cat's eye	

	Шонхорын нүд	Hawk's eye
	Танзанит	Tanzanite
	Ногоолин	Malachite
	Родохрозит	Rhodochrosite
4. Өнгөлгөөний чулуу	Хас	Jasper
	Боржин	Granite
	Чулуужсан мод	Fossilized wood
	Гантиг	Marble
	Галт уулын шил	Moldavite
	Жонш	Flourite
	Баргилт	Agalmatolite

ХАВСРАЛТ 2. АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ⁴⁶

Ашигт малтмалын тухай хуулийн 4-р бүлэгт ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг олгох үе шатыг тусгаж өгсөн байдаг. Үүнд:

1. Өргөдөл гаргах – Хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд ашигт малтмал ашиглахыг хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу АМГТГ-т гаргах ба өргөдөлд доорх зүйлсийг хавсаргана. (24-25-р зүйл) Үүнд:
 - Талбай нь тал бүр тийш 500 метрээс багагүй урттай, уртраг өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн тэгш олон өнцөгт хэлбэртэй байна.
 - Үйл ажиллагаа явуулах талбайн орших аймаг, сум, хот болон дүүргийн нэрийг бичсэн газрын зураг.
 - Өргөдөл гаргагчийн нэр, хаяг, утас, электрон шуудангийн хаяг, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны нэрийг тусгасан тодорхойлолт Өргөдөл гаргагч нь татвар төлөгч хуулийн этгээд мөн эсэхийг нотлох баримт.
 - АМТХ-ийн дагуу хийгдсэн талбайн зураг ба зураг дээр байрлах аймаг, сум, дүүргийн нэрс
 - Үйлчилгээний хөлс төлсөн баримтууд
 - Ашигт малтмал, газрын тосны газрын шийдвэр
 - Хайгуулын ажлын явцад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт.
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.

⁴⁶ Ашигт малтмал, газрын тосны газар - <https://mripam.gov.mn/article/53/>

2. Өргөдлийг хянаж үзэх – АМГТГ ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээж авсны дараа өргөдөл болон хавсралт бичиг баримтуудыг бүртгэх, мөн тэдгээр бичиг баримтууд хуулинд заагдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж, тухайн талбай уурхайн зориулалтаар ашиглах боломжтой эсэх, хайгуул хийж болох талбайн тогтоосон хязгаар дотор байгаа эсэхийг нягтлах ба зарим шаардлагатай тодруулгуудыг хийнэ. (26.1-26.2-р зүйл)
3. Эцсийн шийдвэр – АМГТГ нь өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэр гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан, хуулийн үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ. (26.3-р зүйл)
4. Тусгай зөвшөөрөл хүлээн авагч төлбөр төлөх – Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан этгээд мэдэгдэл авсан өдрөөс хойш 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө. (26.4-р зүйл)
5. Тусгай зөвшөөрөл олгох – Өргөдөл гаргасан этгээд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг хуулийн дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгож, тусгай хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц
6. Мэдэгдэл – Ашигт малтмалын тухай хуулийн 26.7-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны байгууллага нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 7 хоногийн дотор багтааж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн зөвшөөрлөөр олгогдсон талбай орших аймаг, сум, дүүргийн засаг дарга, мэргэжлийн хяналтын газарт энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. (26.7-р зүйл)

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон талбайд ашиглалтын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно. (26.9-р зүйл)

Зөвшөөрөл болон уурхайн талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ. (26.5-26.6-р зүйл)

Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл шинээр авахад бүрдүүлэх материал:

1. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл(маягт К-2)
2. Өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт (маягт К-4)
3. Монгол улсад татвар төлөгч болох тухай нотолгоо (харьяа татварын албаны)

4. Улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар (нотариатаар баталгаажуулсан)
5. Ашиглалт хийх болон үлдэх хайгуулын талбай тус бүрийн байршил, булангийн цэгүүдийн солбицол, хилийг буулгасан зураг тус бүр 2%,
6. Үйлчилгээний хөлс төлсөн баримт (төлбөрийн баримтын эх хувь)
7. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээн авсан Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэр
8. Хайгуулын ажлын явцад Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт
9. Хайгуулын тусгай зөвшөөрөл, хавсралтууд (эх хувь)
10. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн талбай бол сонгон шалгаруулалт явуулсан байгууллага, албан тушаалтны шийдвэр
11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Ашиглалтын тусгай зөвшөөрөл шилжүүлэхэд бүрдүүлэх материал:

1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл шилжүүлэхийг хүснэ үй өргөдөл (маягт К-5)
2. Ашигт малтмалын тухай хуулийн 49.1, 49.3 дах заалтад заасан тохиолдолд үүссэнийг нотолсон нотолгоо
3. Шилжүүлж байгаа тусгай зөвшөөрөл, хавсралтууд; (эх хувь)
4. Шилжүүлж байгаа болон үлдэж байгаа талбайн тодорхойлолт (маягт К-10)
5. Шилжүүлж байгаа болон шилжүүлэн авч байгаа хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (нотариатаар баталгаажуулсан байх)
6. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрч буйг нотлох баримт бичиг (маягт К-7)
7. Үйлчилгээний хөлс төлсөн баримт /төлбөрийн баримтын эх хувь/
8. Тухайн талбайн олборлолт явуулсан хэсэгт нөхөн сэргээлт хийсэн тухай байгаль орчны хяналтын албаны тодорхойлолт
9. Байгаль орчныг нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг АМТ хуулийн 39.1.9-д заасан дансанд төвлөрүүлсэн тухай санхүүгийн баримт
10. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол, байршил, хилийг буулгасан зураг 2 хувь

ХАВСРАЛТ 3. АЛТНЫ СОРЬЦЫГ БАТАЛГААЖУУЛЖ, ХУДАЛДАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ

Алт олборлох зөвшөөрөл бүхий байгууллага, иргэд нь дараах материалыг бүрдүүлэн Үнэт металл сорьцын хяналын газар сорьцоо баталгаажуулан, Монголбанк, арилжааны банкинд худалдана.

1. Үнэт металлын сорьцын хяналтын газарт үнэт металлын сорьц тогтоолгоход бүрдүүлэх материалын жагсаалт

Байгууллага:

- ААНБ-ын гэрчилгээний хуулбар
- Лицензийн хуулбар

Иргэн: Иргэний үнэмлэх

Алтан гулдмай сорьцлуулах төлбөрийн мэдээлэл:

- 0-100 грамм алтан гулдмай 10,000 төгрөг
- 101-500 грамм алтан гулдмай 20,000 төгрөг
- 501-1000 грамм алтан гулдмай 30,000 төгрөг
- 1,001-3,000 грамм алтан гулдмай 40,000 төгрөг
- 3,001-6,000 грамм алтан гулдмай 50,000 төгрөг
- 6,001-12,500 грамм алтан гулдмай 80,000 төгрөг
- 12,501-25,000 грамм алтан гулдмай 100,000 төгрөг

2. Монголбанкинд алт худалдахад бүрдүүлэх материалын жагсаалт

Байгууллага:

1. Лицензийн хуулбар (нэг удаа)
2. ААНБ-ын гэрчилгээний хуулбар (нэг удаа)
3. ААНБ-ын танилцуулга (нэг удаа)
4. Үнэт металлын сорьц тогтоох итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн
5. Нэхэмжлэх

Иргэн:

1. Иргэний үнэмлэх
2. Үнэт металлын сорьц тогтоох итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн
3. Банкин дахь дансны мэдээлэл

Монголбанк нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болох 5 хувийг суутган, алтны үнийг тухай бүр иргэн, аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлдэг.

ХАВСРАЛТ 4. ҮНЭТ ЭДЛЭЛИЙН СОРЬЦЫН БАТАЛГААНЫ ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Сорьцын баталгааны тэмдэг /клейм/ гэдэг ойлголтонд дараах 3-4 тэмдгийг хамруулж үздэг. Хамгийн түрүүнд тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн эзэн эсвэл ивээн тэтгэгчийн барааны тэмдэг дарагдсан байх ёстой. Түүнчлэн үйлдвэрлэсэн эзэн тухайн үнэт металлын сорьцын цифр дарсан байж болно. Тухайлбал: 585, эсвэл 925 гэсэн цифр дарагдсан байвал энэ эдлэлийг 585 сорьцтой алтаар эсвэл 925 сорьцтой мөнгөөр хийсэн байна гэдэг нь шууд ойлгогдох ёстой. Эдгээр тэмгүүдийн дараа тухайн үнэт эдлэлийг шалгаж энэ сорьцоор үйлдвэрлэсэн нь үнэн байна гэдгийг баталгаажуулсан хөндлөнгийн лабораторийн тэмдэг дарагдах ёстой. Зарим улс орнууд тухайлбал Монгол Улс сорьцын баталгааны тэмдэг, сорьцын цифр хоёрыг нэгтгэн нэг тэмдэг болгосон байдаг. Эдгээр 2-3 тэмдэг дарагдсан үнэт эдлэлийг сорьцын баталгаатай бүтээгдэхүүн гэж үздэг. Харин 4 дэх тэмдэг нь олон улсын түвшинд экспортод гаргах шаардлагатай бол олон улсын сорьцын хяналтын байгууллагын баталгааны тэмдэг дарагддаг.

Хэрвээ нэг эдлэл олон хэсэг эд ангиас бүрдсэн байвал эд анги тус бүр дээр нь сорьцын баталгааны тэмдэг дарна. Үнэт эдлэл дээр сорьцын баталгааны тэмдэг дарахад сорьцын хэлбэлзэл нь -2 оос хэтрэхгүй байх ёстой. Сорьцын баталгааны тэмдгийн загварын хэлбэр, цифрүүд нь металлын төрөл бүр дээр өөр өөр байдаг. Тухайлбал: алтан эдлэлийн сорьцын баталгааны тэмдэг зууван дугуй дотор 585 гэсэн цифр байхад мөнгөн эдлэлийн сорьцын баталгааны тэмдэг 6 талтай призм дотор 925 гэсэн цифр байх жишээтэй.

Сорьцын баталгааны тэмдэг дарагдснаар тухайн үнэт эдлэл нь хожим түүх соёлын дурсгалт зүйл болсон тохиолдолд хэн хэдийд хийсэн нь тодорхой байхаас гадна хэзээ ч худалдан борлуулахад бэлэн байх болно. Сорьцын баталгааны тэмдгийн хугацаа нь тухайн эдлэлийнхээ хэрэглээний хугацаатай хамт дуусах болно.

Үнэт эдлэл худалдан авч байгаа иргэн сорьцын баталгааны тэмдгийг сайтар шалгаж авахгүй бол хуурамчаар дууриалган хийсэн тэмдэгтэй, эсвэл үнэт металлаар хийгдээгүй байх зэрэг зөрчлүүд нилээд гаргадаг.

Үнэт металлын сорьцын хяналтын газрын Эрдэнийн чулууны лабораторид эрдэнийн чулууг шинжлэн тодорхойлж гэрчилгээ олгож байна. Эрдэнийн чулуу гэдэг нь нийтлэг ерөнхий ойлголт нэр томъёо боловч Эрдэнэсийн сангийн тухай хуулинд "...Олон улсад хэвшсэн ангилалд хамрагдах үнэт, хагас үнэт чулууг хэлнэ" гэж заасан байдаг. Гоёмсог тод өнгөтэй, тунгалаг байдал, маш хатуу зэрэг чанараараа ховор тохиолдох чулууг эрдэнийн чулуунд хамруулж үзэх боловч байгаль дээр тогтсон өвөрмөц онцгой тогтоц, бүтэц, өнгө үзэмжээрээ ямар ч чулуу онцгой үнэтэй байж болдог. Аль ч үнэт чулуу энгийн нөхцөлдөө үнэ хүрэхгүй байх тохиолдол ч элбэг байдаг. Тийм учраас аливаа чулуунд дундаж үнэ гэж байдаггүй. Зөвхөн тухайн чулуу л өөрийнхөө хэмжээнд тохирсон үнэ хүрдэг.

Чулууг гарал үүслийнх нь хувьд байгалийн /natural/, таримал /synthetic/, хиймэл буюу дууриамал /imitation's/ гэж ангилдаг. Байгаль дээр үүссэн бүх төрлийн чулуу байгалийн гаралтай бол таримал чулуу гэдэгт тухайн чулууны үндсэн найрлагатай түүхий эдийг лабораторийн нөхцөлд ургуулан гаргаж авсан чулууг хэлдэг. Харин хиймэл буюу дууриамал

чулууг энгийн аргаар тухайн чулууг өнгө, гадаад үзэмж талаас нь дууриалган янз бүрийн материалаар хийсэн зүйлийг хэлдэг.

ҮНЭТ МЕТАЛЛ, ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛД СОРЬЦ ТОГТООХ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ⁴⁷

№	АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР	Хэмжих нэгж	Хөлсний хэмжээ /төг-өөр/	
2	Мөнгө, мөнгөн эдлэлд химийн шинжилгээ хийх	ш	6000	
3	Платина, платины бүлгийн металл, эдлэлийн шинжилгээ хийх	ш	35000	
4	Зэрэгцүүлэгч зүүний тусламжтайгаар алтан эдлэлийн сорьц шалгах	ш	1000	
5	Зэрэгцүүлэгч зүүний тусламжтайгаар мөнгөн эдлэлийн сорьц шалгах	ш	1000	
6	Спектрийн болон рентгенофлуоресценцийн аппаратаар сорьц шалгаж, сорьц тогтоох	ш	15000	
7	Сорьцын баталгааны тэмдэг дарж баталгаажуулахад	Алтан эдлэлд	ш	550
		Мөнгөн эдлэлд	ш	150
		1. 0-10 гр жинтэй	ш	220
		2. 11-50 гр жинтэй	ш	320
		3. 51-100 гр жинтэй	ш	420
		4. 101-500 гр жинтэй	ш	520
5. 501-1000 гр жинтэй	ш	620		
6. 1001 гр-аас дээш жинтэй	ш			
8	Платина, платины бүлгийн металлээр хийсэн эдлэлд	ш	850	
10	Алт, мөнгөн эдлэл мөн эсэхийг таних	ш	1000	
11	Алт, мөнгөний хучилттай эсэхийг шалгаж тогтоох	ш	1000	
12	Үнэт металлээр хийсэн эдлэлийн сорьцын баталгааны болон үйлдвэрлэгчийн барааны тэмдэг, тэдгээрийн дардсыг шалгаж экспертиз хийх, сорьцын баталгааны тэмдгийг шинээр болон сэргээн тавихад	Алтан эдлэлд	ш	2000
		Мөнгөн эдлэлд	ш	1000
		Платина, платины бүлгийн металлээр хийсэн эдлэлд	ш	3000
		Импортын алтан эдлэлд шошго зүүж баталгаажуулахад	ш	400
13	Үнэт металл хайлж гулдмайлах	гр	50	
	Мөнгөн ус, циан зэрэг бусад хортой хольцтой алт хайлж гулдмайлахад	гр	200	
14	Алмаз мөн эсэхийг тодорхойлох	ш	10000	
	Алмазыг бүрэн тодорхойлох	ш	45000	
	Алмазыг бүрэн тодорхойлж үнэлгээ хийх	ш	60000	
15	Бадмаараг, индранил, маргад, хувигаан эрдэнийг тодорхойлоход		10000	
			14000	
			18000	

Тайлбар: Яаралтай болон ажлын бус цагаар ажиллахад үйлчилгээний хөлсний хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж авна.

⁴⁷ <https://masm.gov.mn/masmj/харилцагч-таньд/>